

Оюу толгойн БОННУ: Нэмэлт үнэлгээ
Оюу толгой-Гашуун сухайтын замын 3-р бүсийн маршрут

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	3
1.1 ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ	5
1.2 ХУВИЛБАРУУД БА ХЯЗГААРЛАЛТУУД	5
1.2.1 Маршрутын хувилбарууд	5
1.2.2 Захиргааны болон зөвшөөрөлтэй холбоотой хязгаарлалтууд	6
1.2.3 Шинэ зам хамгийн “шилдэг” хувилбар болох нь	6
1.3 ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	7
1.3.1 Тойруулсан маршрут	7
1.3.2 Урт хугацааны төлөвлөлт: Шинэ зам	7
1.3.3 Шинэ замын үндсэн үзүүлэлтүүд	8
2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ	10
2.1 ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТ, ШААРДЛАГУУД	10
2.2 МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ШААРДЛАГУУД	10
2.3 ЗӨВШӨӨРӨЛ, БАТАЛГАА	10
2.4 ОЮУ ТОЛГОЙН ШААРДЛАГУУД	10
2.4.1 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын систем	10
2.4.2 Газар хөндөх зөвшөөрөл	11
2.4.3 Барилгын ажлыг байгаль орчин, орон нутгийн асуудалтай нэгтгэх	11
2.4.4 ОТ компанийн кэмтийн удирдлага	11
3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, БУУРУУЛАХ АРГА ЗАМ	12
3.1 ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	12
3.1.1 Суурь мэдээлэл	12
3.1.2 Нөлөөллийн үнэлгээний арга	13
3.1.3 Бууруулах арга хэмжээний шат дараалал	13
3.2 БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ БА БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ.....	13
3.2.1 Суурь нөхцөл	13
3.2.2 Нөлөөлөл	16
3.2.3 Бууруулах арга хэмжээ	17
3.2.4 Үлдэгдэл нөлөөлөл.....	20
3.2.5 Хяналт шинжилгээ.....	20
3.3 ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ	20
3.3.1 Суурь нөхцөл	20
3.3.2 Нөлөөлөл.....	21
3.3.3 Бууруулах арга хэмжээ	21

3.3.4	Үлдэгдэл нөлөөлөл	22
3.3.5	Хяналт шинжилгээ	22
3.4	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ	22
3.4.1	Суурь нөхцөл	24
3.4.2	Нөлөөлөл	29
3.4.3	Бууруулах арга хэмжээ	30
3.4.4	Үлдэгдэл нөлөөлөл	31
3.4.5	Эерэг нөлөө ахиу үзүүлэх, дүйцүүлэн хамгаалах стратеги	31
3.4.6	Хяналт шинжилгээ	32
3.5	СОЁЛЫН ӨВ	33
3.5.1	Суурь нөхцөл	33
3.5.2	Нөлөөлөл	34
3.5.3	Бууруулах арга хэмжээ	34
3.5.4	Үлдэгдэл нөлөөлөл	35
3.5.5	Хяналт шинжилгээ	35
4.	ТАЛУУДЫН ОРОЛЦОО	35
4.1	МАЛЧИД	35
4.2	ГБДЦГ-ын ЗАХИРГАА, ХАЙРХАН БАГИЙН ЗАСАГ ДАРГА	35
4.3	ЦАГААН ХАД	36
5.	АЖИЛЛАХ ХҮЧ БОЛОН АЖЛЫН НӨХЦӨЛ	36
6.	ХУРИМТЛАГДСАН НӨЛӨӨЛӨЛ	36
7.	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ДҮГНЭЛТ	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1:	Шинэ замын чиглэл	4
Зураг 2:	Шинэ замын зурвасын дагуух хөрсний элэгдэл, эвдрэл	15
Зураг 3:	Түр замын дагуух ургамлын төрөл	26
Зураг 4:	2014 онд ЭР-ийн зам болон Нүүрсний замыг хөндлөн гарсан хулангийн мөр үлдсэн хэсгүүд	28

1. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү Нэмэлт үнэлгээг Оюу толгой ХХК (ОТ) дотоод үнэлгээ, дүн шижилгээнийхээ ажилд ашиглах зорилгоор боловсруулан гаргасан бөгөөд дотооддоо ашиглах баримт бичиг юм. Энэ нь Оюу толгойн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ)²-нд тодорхойлон, үнэлсэн “Төсөл”¹ болон Түр замын нэмэлт үнэлгээнд³ орсон өөрчлөлтүүдийг авч үзнэ.

ОТ компани Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх дэд бүтцийн зурвасын 3-р бүс буюу Цагаан хаднаас Монгол–Хятадын хилийн боомт хүртэлх замын зураг төсөл, барилгын ажил, ашиглалтад дахин өөрчлөлт оруулсан;

Шинэ зам нь (*Зураг 1*) Энержи Ресурсийн (ЭР) төлбөртэй замтай зэрэгцээ орших, нэг урсгалтай байнгын засмал зам байх ба нийт уртынхаа гуравны нэгт одоо байгаа, хатуу хучилтгүй Түр замтай давхцана. Шинэ зам ашиглалтад орсноор хойноос урагшаа чиглэсэн хөдөлгөөний ачаалал авах ба ЭР-ийн зам урдаас хойш чиглэсэн хөдөлгөөний ачаалал авснаар Цагаан хад болон Монгол–Хятадын хилийн хооронд өөр өөр чиглэлийн олон замтай байсантай харьцуулахад бүх чиглэлийг нэгтгэсэн нэг замтай болох юм. Шинэ замын барилгын ажлыг 2015 оны 7-р сард эхлүүлэхээр төлөвлөсөн.


Энэхүү Нэмэлт үнэлгээнд доорх асуудлыг тодорхойлсон:

- төлөвлөлтийн түүх, харгалзан үзэж байсан хувилбарууд болон санал болгож буй өөрчлөлтийн цаадах үндэслэл;
- бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн болон төслийн шаардлагуудад нийцүүлэх асуудал (Шинэ зам барих зөвшөөрлийг тусад нь авч үзэхийг анхаарах);⁴
- байгаль орчин, нийгмийн суурь нөхцөл байдалд дээрх үйл ажиллагааны улмаас үүсэж болзошгүй нөлөөлөл, эрсдэл;
- сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хэрэгжүүлсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
- үлдэгдэл эрсдэлийн хэр хэмжээ;
- ОТ компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд (БОНУТ) хамаарах хяналт шинжилгээ, удирдлагын асуудал.

Үнэлгээ хийх зорилгоор энэхүү Нэмэлт үнэлгээний суурь нөхцөлийг 2012 оны 8-р сард зарласан ОТ БОННУ⁵, 2012 оны Түр замын БОННБНУ⁶, 2015 оны Шинэ замын БОННБНУ⁸-ний суурь судалгаанд тус тус тусган оруулсан мэдээллүүдээс тодорхойлон гаргасан. Бууруулах арга хэмжээг БОННУ-ний хүрээнд боловсруулан гаргасан ОТ компанийн Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөө (ҮАУТ)–өөс авсан. ОТ-с дотоодын эрсдэлийн удирдлагын чиглэлээр гаргасан Түр замын Газар хөндөх зөвшөөрөлд (ГХЗ) шаардлагуудыг тусгасан⁹. Нөлөөллийг бууруулах талаар гаргасан өөр бусад эх үүсвэрүүдийг мөн дурдсан байна.

- ¹ БОННУ-нд зааснаар “Төсөл” гэдэг нь нь төслийн төлөвлөгөө, нөлөөллийн удирдлага, бууруулах арга хэмжээгээр дамжуулан ОТ–н зүгээс удирдлага хяналт тавьж, нөлөөлөх боломжтой шууд үйл ажиллагаанаас бүрдэнэ. Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх дэд бүтцийн зурвас нь БОННУ-нд шууд үнэлгээ хийсэн Төслийн нэг элемент болсон.
- ² Оюу толгойн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2012).
- ³ Оюу толгойн БОННУ-ний Нэмэлт үнэлгээ - Түр зам ба Тойруулсан маршрут (2012).
- ⁴ ОТ компани захиргааны зөвшөөрлийг Монгол Улсын тогтоомжоор шаардсаны дагуу энэхүү Нэмэлт үнэлгээнээс тусад нь авч үзэн Зам, тээврийн яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас авах гэж байгаа.
- ⁵ Оюу толгойн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (2012).
- ⁶ Nature Friendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” (2012).
- ⁷ Оюу толгойн БОННУ-ний Нэмэлт үнэлгээ - Түр зам ба Тойруулсан маршрут (2012).
- ⁸ JEMR ХХКийн боловсруулсан 2015 онд баригдах Цагаан хаднаас Гашуун сухайт хүрэх засмал замын БОННУ-ний суурь судалгаа (2014)

Зураг 1: Шинэ замын маршрут



ЭР-ГС засмал зам

⁹ Түр замын ГХЗ нь Шинэ замын зурвас дотор олгогдоно гэж үзсэн. Шинэ замын ТЭЗҮ болон БОННБНҮ-г бүрэн гүйцэтгэснээр Шинэ замын ГХЗ авах ажлыг эхлүүлнэ.

ОТ-н Олон талт хамтын ажиллагааны төлөвлөгөөнд (ОТ-05-PLN-001) тусгагдсан шаардлагуудыг энэхүү үнэлгээний үйл явцтай нэгэн зэрэг авч үзсэн.

1.1 ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Замын маршрутад оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн үндэслэл:

- Гашуун сухайт хүрэх замыг бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд нийцэж чадах нэгдсэн нэг замын системтэй болгох шаардлагатай байна (ОТ компанийн тээврийн хэрэгсэл, нүүрсний машин, нийтийн зориулалттай тээврийн хэрэгсэл);
- Цаашид дахиж өөрчлөгдөх, хөндлөнгийн нөлөөнд өртөх магадлал хамгийн багатай байх замын чиглэлийг баталж, ашиглалтад оруулсах нь ОТ компанийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах болно;
- Энержи ресурсийн төлбөртэй замтай зэрэгцээ маршрут сонгосноор ГБДЦГ-ын Б хэсгийг дайруулан олон тооны зам гаргахгүй болох тул байгаль орчинд үлдээх ул мөр, нөлөөллийг бууруулна;
- Нэг чигийн хөдөлгөөнтэй зам ашигласнаар замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжирна;
- Төлөвлөсөн төмөр зам (ОТ компанийн хяналтаас гадуур) одоо батлагдсан байгаа замын маршрутыг гурван газраар дайрч гарч байгаа бол шинээр санал болгож буй замын маршрутыг нэг газраар дайран өнгөрнө.

1.2 ХУВИЛБАРУУД БА ХЯЗГААРЛАЛТУУД

1.2.1 Маршрутын хувилбарууд

ГБДЦГ-ын Б талбайн урд хэсэгт орших Монгол-Хятадын хилийн Гашуун сухайт боомт руу очих албан ёсны болон албан ёсны бус олон зам гарсан байгаа. Өмнөговийн нутагт биеэ даасан үйл ажиллагаа явуулж буй өөр өөр байгууллагуудын гүйцэтгэсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын үр дүнд олон тооны замууд бий болсон.

Гашуун сухайт руу очих маршрутыг анх төлөвлөж эхэлсэн цагаас хойш ОТ хэд хэдэн хувилбарыг авч үзсэн. Төлөвлөлт нь гадаад, дотоод хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж ирсэн. Ерөнхийдөө:

- **Анхны маршрут.** ОТ БОННУ¹⁰ -д тодорхойлон заасан Анхны маршрут. Уг маршрут нь улсын чанартай зам бөгөөд ОТ компанийн хэрэгцээнд болон нийтийн зориулалттай тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд ашиглах зорилгоор ОТ компани уг замыг улсын чанартай замд тавигдах бүхий л шаардлагад нийцсэн хатуу хучилттай зам болгон сайжруулах шаардлагатай гэж БОННУ-нд тусгасан.

ОТ компани Монгол Улсын Засгийн газраас өгсөн удирдамжийн дагуу улсын чанартай замын маршрутыг цэргийн ангийн нутаг дэвсгэрээс холдуулах шаардлагатай болсон нь замын барилгын ажилд тавигдах нэг хязгаарлалт болсон юм. Ингэснээр 2012 онд

“Тойруулсан маршрут”¹¹-ыг гаргаж тусад нь үнэлгээ хийсэн. Анхны маршрутын Цагаан хаднаас Гашуун сухайт хүрэх хэсгийг нүүрсний машин ихээр ашиглах болсны улмаас ОТ компанийн тээврийн хэрэгслүүд хилийн боомтоор нэвтрэхэд туйлын хүндрэлтэй, замын хөдөлгөөний нөхцөл байдал аюултай болж, уг маршрутын дагуу улсын чанартай замын барилгын ажлыг гүйцэтгэхэд саад болсон.

- **Шинэ маршрут** нь ЭР-ийн замтай зэрэгцээ орших, нэг урсгалтай байнгын засмал зам байх ба 18.6 км уртынхаа 6.4 км-т нь одоо байгаа Түр замтай давхцана. Шинэ зам ашиглалтад орсноор хойноос урагшаа чиглэсэн хөдөлгөөний ачаалал авах ба ЭР-ийн зам урдаас хойш чиглэсэн хөдөлгөөний ачаалал авснаар Цагаан хад болон Монгол–Хятадын хилийн хооронд өөр өөр чиглэлийн олон замтай байсантай харьцуулахад бүх чиглэлийг нэгтгэсэн нэг замтай болох юм. Түр замын маршрутын зарим хэсгийг өөрчилсний шалтгаан нь сөрөг нөлөөллийг нь бууруулах, замыг илүү аюулгүй болгох үүднээс маршрутыг шулуун (огцом эргэлт байхгүй) болгоход оршино.

¹⁰ Оюу толгойн БОННУ (2012) А хэсэг: Танилцуулга болон үндэслэл. А4-р бүлэг – Төслийн тодорхойлолт; А5-р бүлэг – Маршрутын хувилбаруудын шинжилгээ.

¹¹ Оюу толгойн БОННУ-ний Нэмэлт үнэлгээ (2012), Түр зам болон Тойруулсан маршрут.

Шинэ замыг барьснаар ГБДЦГ-ыг дайрч өнгөрөх олон тооны замыг хэрэглэх шаардлагагүй болж, дээрх замуудаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулна. Нэгдсэн нэг системийн үүрэг гүйцэтгэх, нэг урсгалтай зэрэгцээ замуудыг ашигласнаар шинэ зам нь замын аюулгүй байдлыг сайжруулна.

- **Энержи ресурсийн зам.** Энержи ресурс тэргүүтэй нүүрсний компаниудын консорциум Цагаан хад болон хилийн боомтын хооронд нүүрс тээвэрлэх зориулалтын засмал замтай болох зорилгоор ЭР-ийн замыг барьсан. ЭР-ийн зам төлбөртэй зам тул зарим машин төлбөр төлбөхөөс зайлсхийж замгүй газраар явах эсхүл улсын чанартай замаар явах болсон, мөн жингийн хязгаарлалт тогтоосноор заасан жингээс хэтэрсэн ачаатай явдаг нүүрсний машинууд уг замыг ашиглах нь хязгаарлагдмал болсон¹².

- **Хатуу хучилтгүй түр зам.** ЭР-ийн засмал замыг барих үед уг түр замыг ашиглаж байсан. ОТ компани улсын чанартай замыг сайжруулах ажлыг гүйцэтгэх байх хугацаанд уг замыг тээврийн хэрэгслийн чиглэлийг өөрчлөхөд ашиглах нь хамгийн тохиромжтой хувилбар гэж тодорхойлж байсан. 2013-2014 онд нүүрсний экспорт буурч, бөглөрөл багасах болсон, мөн бөглөрөлтэй гэсэн шалтгаанаар Анхны маршрутыг сайжруулаагүй байгаа тул ОТ компани одоогоор ЭР-ийн замыг ашиглаж байна. ОТ компанид санал болгосон боловч Түр замыг ашиглахгүй байгаа бөгөөд уг замаар нүүрсний машин явуулахгүйн тулд хоёр талд нь байнгын харуул тавьж, хаалт хийсэн.

1.2.2 Захиргааны болон зөвшөөрөлтэй холбоотой хязгаарлалтууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлыг зохицуулсан захиргааны хэм хэмжээ болон хил хүрэх замын эцсийн маршрутыг тогтоож, урт хугацааны оновчтой шийдэлд хүрэхийн тулд олон талын оролцоотой шийдвэр гаргах хэрэгтэй байгаа зэрэг нь маршрутын хувилбарыг сонгоход тавигдах хязгаарлалтын хүчин зүйл болж байна. Замын маршрутын хувилбарууд нь бүгд Хятадтай хиллэх хилийн “хязгаарлалтын бүс”-д байрлах тул Хил хамгаалах ерөнхий газрын удирдлага хяналтад байдаг.

Шинэ зам, Түр зам, ЭР-ийн замууд нь нийтдээ ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсэд оршино. Харин Анхны маршрутын зарим хэсэг нь ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсэд, үлдсэн хэсэг нь Орчны бүсэд (энэхүү дэд бүтцийн бүтээн байгуулалт нь Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд хамаарна (1997)) оршино. Шинэ замын зөвшөөрөл авах асуудлыг энэ тайлангаас тусад нь авч үзнэ.

1.2.3 Шинэ зам хамгийн “шилдэг” хувилбар болох нь

ЭР-ийн замтай зэрэгцээ орших хоёр эгнээтэй засмал зам болох шинэ замыг барьснаар үүсэх эерэг нөлөөлөл нь ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсэд зам барьснаар үүсэх сөрөг нөлөөллөөс илүү байна гэж үзсэн.

Шинэ замын маршрутыг боловруулахдаа Гашуун сухайт хүрэх замын байгаль орчны нөлөөллийг бууруулах ОТ компанийн арга барилд тулгуурлан, ЭР-тэй зөвлөлдөж, хамтран ажилласан.

Эерэг нөлөөлөлд доорх багтана:

- хатуу хучилтгүй замаар эсвэл замгүй газраар тээврийн хэрэгсэл явсны улмаас нутаг дэвсгэрийг их хэмжээгээр эвдэн сүйтгэж байгааг бууруулах;
- замын хөдөлгөөнийг нэг урсгалтайгаар зохион байгуулах замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах; Анхны маршрут нь бусад хувилбаруудтай харьцуулахад хамгийн богино зай юм;
- Шинэ зам нь одоогийн байгаа замын зурваст багтах бөгөөд боломжтой газар нь ЭР-ийн одоо байгаа замын маршрутын дагуу явна (хамгийн холдоо 400 м алсална);
- зам барилгын ажлыг аюулгүй гүйцэтгэх боломжтой, замын хөдөлгөөнийг өөрчилж, улсын чанартай замыг ашиглах шаардлагагүй.

Замын байршлын улмаас байгаль орчны эмзэг нөхцөл газар нутагт үзүүлэх нөлөөллөөс бүрмөсөн зайлсхийх боломжгүй байгаа тул нөлөөллийг бууруулах шат дарааллын дагуу нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

¹² ОТ гадагш гарах бүх машины нийт жинг нарийн хэмжиж, тэнхлэгт ногдох жингийн

хязгаарлалтыг Монгол Улсын стандартын шаардлага, төслийн стандартад нийцүүлдэг тул жингийн хязгаарлалтыг зөрчдөггүй.

1.3 ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Оюу толгойн уурхайн талбай болон Цагаан хадны хоорондох улсын чанартай замыг сайжруулах ажлыг бүрэн гүйцэтгэсэн.

Цагаан хад болон Гашуун сухайтын хоорондох Анхны маршрут нь Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн баруун хилтэй зэрэгцэн, ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсээр дамжин Гашуун сухайт хүрэх, “Нүүрсний зам” гэгдэж буй одоогийн байгаа хатуу хучилтгүй замын дагуу байсан.

1.3.1 Тойруулсан маршрут

Монгол Улсын зэвсэгт хүчний цэргийн ангийн нутаг дэвсгэрээс холдуулахын тулд Анхны маршрутыг 2011 онд шинэчлэн өөрчлөх шаардлагатай болсон. Гэсэн хэдий ч сайжруулахаар төлөвлөсөн уг маршрутаар явж буй хүнд даацын нүүрсний машины хөдөлгөөнөөс үүдэлтэй аюулгүй ажиллагааны эрсдэлийн улмаас ОТ компани 2011 онд тухайн замыг өөрийн хэрэгцээнд зориулан сайжруулах боломжгүй байсан. ОТ компани түр хугацаагаар ашиглах хувилбарыг хайсны эцэст ЭР-ийн засмал замыг барьж байх явцад Энержи ресурсийн ашиглаж байсан хатуу хучилтгүй “Түр зам”-ыг сонгон ашиглах болсон. Төсөлд оруулсан дээрх өөрчлөлтийг 2012¹³ онд зээлдүүлэгчдэд танилцуулж, батлуулсан Нэмэлт үнэлгээнд тусган оруулсан.

Тойруулсан маршрутыг бариагүй, Түр замыг ашиглаагүй байгаа бөгөөд ОТ одоогийн байдлаар ЭР болон ТТ компанийн нүүрс тээврийн машинууд, нийтийн зориулалттай тээврийн хэрэгслүүдтэй хамт ЭР-ийн замыг ашиглаж байна.

1.3.2 Урт хугацааны төлөвлөлт: Шинэ зам

Цагаан хад хүрэх болон Цагаан хаднаас Гашуун сухайтын хилийн боомт хүрэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулахын тулд урт хугацааны шийдэл шаардлагатай гэдэг нь эхнээсээ тодорхой байсан. Гэхдээ хилийн боомт хүрэх тээвэрлэлтийн бусад маршрутын төлөвлөгөө тодорхой бус байсны улмаас уг асуудлыг шийдэхэд хэцүү болсон. Урт хугацааны шийдэлд хүрэхийн тулд ЭР болон Монгол Улсын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай болох нь тодорхой. 2011 онд уг асуудал анх үүссэн цагаас эхлэн ОТ компани бусад оролцогч талуудтай идэвхтэй хамтран ажиллаж ирсэн. ЭР болон ОТ компани энэ чиглэлээр зөвшилцөлд хүрч, Цагаан хадыг Гашуун сухайтын хилийн боомттой холбосон дөрвөн эгнээтэй нэгдсэн хурдны зам барихад нөөц бололцоогоо нэгтгэхээр боллоо.

ОТ компани Цагаан хад болон Гашуун сухайтын хоорондох ЭР-ийн замтай зэрэгцэн орших байнгын засмал зам (“Шинэ зам”) барихаар төлөвлөж байна. Шинэ зам

ашиглалтад орсноор уг зам нь ЭР-ийн замтай нийлээд нийт дөрвөн эгнээ, хоёр урсгалтай (нэг урсгал нь хоёр эгнээтэй) зам болох ба ОТ, ЭР компанийн болон бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлэх нэгдсэн нэг систем болох юм. Шинэ замаар МУ-с гарах замын хөдөлгөөн (хойноос урагш) харин ЭР-ийн замаар Хятадаас Монгол улс руу орох замын хөдөлгөөн (урдаас хойш) дамжин өнгөрнө.

Шинэ зам (Зураг 1) нь Оюу толгойгоос Ханбогд хүрэх улсын чанартай замын уулзвараас эхлэх бөгөөд Цагаан хаднаас урагш явсан ЭР-ийн замаас Гашуун сухайтын хилийн боомтын гаалийн байгууламжийн орц/гарц хүртэл үргэлжилнэ.

Шинэ замын маршрут нь ЭР-ийн төлбөртэй замын баруун талд орших ба хамгийн холдоо 400 метрээс ихгүй зайтай байна. Уг замын маршрутыг одоо байгаа хатуу хучилтгүй Түр замтай аль болох давхцахаар (нийт 18.6 км уртын 6.4 км нь) сонгосон. Гэхдээ зэрлэг ан амьтдын амьдрах орчныг дайран өнгөрөхгүй байх, мөн Засгийн газраас барихаар төлөвлөж буй төмөр замын чиглэлийг харгалзан үзэх үүднээс зарим газарт өөрчлөлт оруулсан.

ТЭЗҮ-ийн хүрээнд гүйцэтгэсэн замын хөдөлгөөний судалгаанд ашиглалтын эхний жилд тус замаар хоногт ойролцоогоор 600 ачааны машин, 50 зорчигч тээврийн хэрэгсэл явна гэж тооцоолсон. 2034 онд тус замаар хоногт ойролцоогоор 1,100 хүнд даацын ачааны машин, 600 зорчигч тээврийн хэрэгсэл явна гэж тооцоолжээ¹⁴.

¹³ Оюу толгойн БОНБНҮ-ний Нэмэлт үнэлгээ (2012), Түр зам болон Тойруулсан маршрут.

¹⁴ Замын хөдөлгөөний ачааллыг Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төвийн мэдээлэл болон Гашуун сухайт боомтын мэдээллээс тооцоолон гаргав.

1.3.3 Шинэ замын үндсэн үзүүлэлтүүд

Шинэ замын төслийн тоймыг дор тайлбарлав.

Маршрут болон хэмжээс

- Шинэ замын маршрут нь одоо байгаа ЭР-ийн замын баруун талаар үргэлжлэх ба хоёр замын хооронд хамгийн ихдээ 400 метрийн зайтай байна.
- Замын нийт өргөн нь 12 м бөгөөд 8 метр өргөн хатуу хучилттай гадаргуутай, 2 талдаа тус бүр 2 метр өргөн хөвөөтэй байна.
- Шинэ зам нь одоо байгаа хатуу хучилтгүй Түр замтай 6.4 км газарт давхцан оршино (ойролцоогоор замын нийт уртын гуравны нэг).
- Шинэ замын зураг төсөл нь маршрутыг шулуун болгож, ЭР-ийн замын шалган нэвтрүүлэх цэгийн зүүн хэсгийг дайрч өнгөрнө.
- Төлөвлөсөн замын нийт урт нь 18.6 км.

Төлөвлөсөн замын байгууламж

- Гадаргын урсац илэрсэн талбайд 1 м диаметртэй 16 ширхэг дугуй огтлолтой ус гаргуур, 2x2 хэмжээтэй 1 ширхэг тэгш өнцөгт огтлолтой ус гаргуураар гадаргын усыг зайлуулна.
- Малын гарцыг төлөвлөсөн. Энэ нь мал сүрэг болон малчин ард иргэд замын далан руу авирах шаардлагагүйгээр зам хөндлөн гарах боломж олгосон налуу гарц байх ба Цагаан хадны хойд хэсэгт байх Оюу толгойн замд ашигласантай төстэй гарц байна. Гарцын байршлыг хараахан төлөвлөөгүй.

Газар хөндөх

- Өнгөн хөрсийг нь хөндөх нийт талбайг 516,200 м² байхаар тооцоолсон.
- Буцаан дүүргэлт, малталт, ус зайлуулах хоолой гаргах, замын хөвөөнд ашиглах зорилгоор ойролцоогоор 233,000 м³ шороо зөөвөрлөнө.

Голын гарам

- Төслийн талбайд байнгын урсац байхгүй ч төлөвлөсөн зам нь хоёр газарт томоохон түр урсац үүсэх системийг дайрч өнгөрнө.
- Цагаан хаднаас урагш 1.5 км-т орших, 1 м диаметртэй 16 ширхэг дугуй огтлолтой ус гаргуураас бүрдэх ус зайлуулах системийг дайран өнгөрч буй замын 170 м хэсгийг үерийн ус өнгөрөөх хийцтэй барина.
- Гашуун сухайтын хилийн боомтоос хойд зүгт 2 км-т орших өмнөд хэсгийн үерийн урсац бүхий газарт 2x2 м хэмжээтэй тэгш өнцөгт огтлолтой ус гаргуурыг тусгасан.

Замын тэмдэг тэмдэглэгээ

- Замын дагуу 23 ширхэг замын тэмдэг, 18 ширхэг зайн тэмдэглэгээ, 3 ширхэг мэдээлэх тэмдэг байрлуулна.

Замын хөдөлгөөн

- Замын барилгын ажилд шаардлагатай материалын нийлүүлэлт, тээвэрлэлтийн асуудлыг хараахан эцэслээгүй байгаа ч замын ТЭЗҮ-д дараах мэдээллийг тусгасан байна:
 - Бусад хувилбартай харьцуулахад зардал, хугацаа хэмнэх тул цемент, ган арматур, битум зэрэг замын барилгын ажилд хэрэглэх бүх материалыг Хятадаас нийлүүлнэ;
 - Төлөвлөж буй төслийн талбайтай ойр тул химийн бусад бодис, нэгдлийг (доломит, шохой г.м) Хятадаас нийлүүлэх магадлалтай байна;
 - Зам барилгын ажлын явцад асфальт, бетоны үйлдвэр (хоёулаа 80-120 тонн/цаг хүчин чадалтай), бутлуур, бульдозер, грейдер, замын индүү, усны болон хогийн машин зэрэг 60 орчим зөөврийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг ашиглахаар төлөвлөсөн.

Карьер

Хайрга болон элсийг 2011 онд ЭР-ийн замын барилгын ажилд ашигласан дөрвөн карьераас авна. Эдгээр карьер нь ГБДЦГ-ын Б хэсгийн гадна гэхдээ ГБДЦГ-ын Б хэсгийн Орчны бүс дотор байрлана.

- Нэмэлт карьер гаргах шаардлагагүй гэж тооцсон. Гэхдээ барилгын ажлын явцад нэмэлт дүүргэх материал шаардлагатай болбол тэдгээрийг ГБДЦГ-ын Б хэсгийн гадна талд гаргах бөгөөд Газар хөндөх зөвшөөрөл олгох дотоод журам болон БОНБНУ-нд заасан захиргааны шаардлагуудад захирагдана.

Ус хангамж

- Төслийн барилгын ажлын усны хэрэгцээг ЭР¹⁵-ын замын дагуу гаргасан худгуудаас хангана. Худаг түгжээтэй байгаа бөгөөд малчид зэрэг бусад хэрэглэгчид ашиглаагүй.
- Таван толгой болон Гашуун сухайтын хоорондох төмөр замын төсөлд ашиглаж буй усны цооногийг Төслийн усны хэрэгцээнд ашиглаж болно¹⁶.

Барилгын ажлын хугацаа

- Зам, тээврийн яамнаас ТЭЗҮ-ийг батлах хугацаанаас хамааран замын барилгын ажлыг 2015 оны 7-р сард эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд өвлийн цагт барилгын ажил түр зогсох хүртэл буюу 2015 оны 11-р сар хүртэл үргэлжилнэ. Барилгын ажил 2016 оны 4-р сард дахин эхэлж, тухайн оны 11-р сард дуусгахаар төлөвлөсөн.

¹⁵ Худгийн байрлал GGW32 694345 4741618.

¹⁶ Биологийн олон янз байдлын зөвлөх болон Барилга, инженерийн хэлтсийн хоорондох аман тохиролцоо.

2. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү Нэмэлт үнэлгээг ОТ компани захиргааны зөвшөөрөл авахад биш харин дотоодын үнэлгээ, дүн шинжилгээ хийхэд зориулан гаргасан.

2.1 ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТ, ШААРДЛАГУУД

ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт болон ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогод заасан гүйцэтгэлийн шаардлагын дагуу Байгаль орчин, нийгмийн болзошгүй нөлөөллийн үнэлгээг хийсэн. ОУСК болон ЕСБХБ-ны шаардлагын талаар Оюу толгойн БОННУ-нд дэлгэрэнгүй тусгасан болно¹⁷.

2.2 МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ШААРДЛАГУУД

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах шаардлагуудыг Оюу толгойн БОННУ-нд дэлгэрэнгүй тусгасан хууль, эрх зүйн актуудад дэлгэрэнгүй тусгасан байдаг. Байгаль орчныг хамгаалахаас гадна газар, газар ашиглалт, газрыг тусгай хэрэгцээнд авах болон уламжлалт газар ашиглалтыг зохицуулсан хууль эрх зүйн актууд байдаг. Мөн Монгол Улс нь амьтан, ургамлын аймгийг хамгаалах, биологийн олон янз байдал, тогтвортой хөгжил, эрчим хүч, уур амьсгалын өөрчлөлт, ус, биет болон биет бус соёлын өвийн тулаарх олон улсын хэд хэдэн гэрээ хэлэлцээрт нэгдсэн. ГБДЦГ-ын Б хэсэгт явуулах бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд нэн чухал нөлөө үзүүлэх хууль, эрх зүйн актуудын талаар Оюу толгойн БОННУ-нд дэлгэрэнгүй авч үзсэн¹⁸.

2.3 ЗӨВШӨӨРӨЛ, БАТАЛГАА

Шинэ зам нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд (1995 оны хуульд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) заасан ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсэд байрлана. Шинэ замын ТЭЗҮ батлагдмагц ОТ компани Хязгаарлалтын бүсэд баригдах замд шаардлагатай албан ёсны зөвшөөрлүүдийг авна (Анхны маршрутад өмнө нь авсны нэгэн адилаар).

Карьерууд нь Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд (1997) заасан ГБДЦГ-ын Б хэсгийн Орчны бүсэд байрлана. Тусгай хамгаалалттай газарт учруулах сөрөг нөлөөллөөс, бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд тусгай хамгаалалттай газар нутгийн эргэн тойронд Орчны бүс байгуулсан байдаг. Карьерын зөвшөөрөл авахын тулд БОНБНУ-г батлуулах шаардлагатай. ТЭЗҮ-ийг баталсны дараа БОНБНУ-г хүргүүлнэ.

2.4 ОЮУ ТОЛГОЙН ШААРДЛАГУУД

2.4.1 Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын систем

ОТ компани нь Рио Тинтогийн стандартад нийцсэн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны нэгдсэн удирдлагын систем (ОТ ЭМААБОУС) болон Орон нутаг, нийгмийн хариуцлагын удирдлагын системийг (ОННХУС) хэрэгжүүлдэг.

ОТ БОННУ-нд заасан байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, эрсдэлийг бууруулах арга хэмжээг ОТ ЭМААБОУС болон ОТ ОННХУС-д тусгасан байдаг. Удирдлагын системийг Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагууд болон олон улсын салбарын шилдэг туршлагад нийцүүлэн боловсруулсан бөгөөд ОТ ЭМААБОУС нь олон улсын байгаль орчны удирдлагын стандарт ISO14001 -аар баталгаажсан.

Байгаль орчин, нийгмийн тодорхой асуудлын хувьд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын дэлгэрэнгүйг доорх баримт бичгүүдэд шат дараалан тусгасан:

- Удирдлагын төлөвлөгөө: Үүнд удирдлагын үндсэн хяналт болон холбогдох удирдлагын үйл ажиллагаа, стандарт, хяналтыг тодорхойлсон.
- Журам, хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө, удирдамж, бодлогын баримт бичиг:

(хэрэгжүүлэлтийн баримт бичиг): эдгээр баримт бичгийг ЭМААБО болон ОННХ-ын үр ашигтай төлөвлөлт хяналтанд ашигласан бөгөөд ОТ компанийн ажилтны гүйцэтгэх үйл ажиллагааны явцад удирдлагын хяналтыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэх ажил үүрэг, үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгасан¹⁹.

¹⁷ Оюу толгойн БОННУ (2012) А хэсэг: Танилцуулга, үндэслэл. А2-р бүлэг – Бодлого болон хууль эрх зүйн орчин.

¹⁸ Оюу толгойн БОННУ (2012) А хэсэг: Танилцуулга, үндэслэл. А2-р бүлэг – Бодлого болон хууль эрх зүйн орчин.

Гэрэт гүйцэтгэгчийн удирдлага

Бүх гэрээт гүйцэтгэгч нар ОТ компанийн Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын тогтолцоо (ОТ-07-PLN-0001) -нд тусгасны дагуу ОТ БОУС-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний үүрэг хүлээх бөгөөд үүнд ОТ компанийн Хангамжийн зарчмын дагуу хяналт тавина. Үүрэг хариуцлагад ОТ компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд (БОНУТ) заасан гүйцэтгэгчийн ажлын хамрах хүрээтэй холбоотой нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг багтана.

2.4.2 Газар хөндөх зөвшөөрөл

ОТ ЭМААБОУС-д ОТ компанийн Газар хөндөх зөвшөөрлийн (ГХЗ) журмын (ОТ-10-Е-PRC-0001) дагуу ОТ компани болон түүнийг төлөөлсөн этгээд нутгийн уугуул ургамал хөндөх зэрэг газар хөндөх үйл ажиллагааны өмнө төслийн талбайн нөхцөлд үнэлгээ хийх шаардлагыг нэгтгэн оруулсан.

Байгаль орчны шаардлагад өнгөн хөрс хамгаалах, ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйлийг хамгаалах, зэрлэг ан амьтан, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, усны нөөц болон чанарыг хамгаалах ажлуудыг харгалзан үзсэн. Мөн хууль, эрх зүйн болон бусад шаардлагын (БОННУ-ний шаардлага зэрэг) хэрэгжилтийг харгалзан үзнэ.

Шинэ замын ТЭЗҮ болон БОННУ-г баталснаар газар хөндөхийн өмнөх хяналт шалгалтыг хийж, ГХЗ-ийг гаргана. Гүйцэтгэгч нар барилгын ажлын явцад ГХЗ-ийн нөхцөлд нийцүүлэн ажиллах шаардлагатай. ОТ компанийн байгаль орчны мэргэжилтнүүд ашиглалтын нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах зорилгоор хууль, эрх зүйн хэрэгжилтийн хяналт шалгалт явуулна.

2.4.3 Барилгын ажлыг байгаль орчин, орон нутгийн асуудалтай нэгтгэх

ОТ компанийн Барилга, инженерингийн баг (БИБ) зам барилгын ажилтай холбоотой асуудлаар (БОНБНУ, БОНУТ, хяналт шинжилгээ, ГХЗ, талуудын оролцоо) Бүсийн хөгжил, нийгмийн хариуцлага (БХНХ) болон ЭМААБО-ны хэлтэстэй хамтран ажиллана. Ингэснээр барилгын ажил болон гэрээт компанийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгаль орчин, орон нутагт үзүүлэх болзошгүй нөлөөллийг авч үзнэ.

Үндсэн элементүүдийг доор харуулав:

- Төслийн удирдлагын баг болон ОТ компанийн БХНХ хэлтэс, Байгаль орчны хэлтсийн хоорондын уялдаа холбоог хангах;
- Барилгын төлөвлөсөн ажлууд, ялангуяа орон нутагт илүү их нөлөөлөл үзүүлэх “төслийн талбайн гаднах” үйл ажиллагааны талаарх мэдээллээр цаг алдалгүй хангах;
- Барилгын ажлын гүйцэтгэл болон нөлөөлөлтэй холбоотой ОТ компанийн БХНХ хэлтэс болон Байгаль орчны хэлтсийн мэдээллийг цуглуулах, хянах, тараах; Асуудал гарахаас урьдчилан сэргийлэх, гарсан асуудлыг шийдвэрлэх үүднээс ОТ компанийн БХНХ хэлтэс болон Байгаль орчны хэлтэстэй хамтран ажиллах.

2.4.4 ОТ-н кэмийн удирдлага

ОТ компанийн кэмийг Монгол Улсын холбогдох стандарт, ОТ компанийн кэмийн стандарт болон зан байдлын дүрмийн (HR-ST-01) дагуу удирдан зохицуулж, ОУСК болон ЕСБХБ-ны удирдамжийг дагаж мөрдөнө²⁰.

¹⁹ ОТ компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөний (ОТ-10-PLN-0003) 1-р хүснэгтэд Удирдлагын төлөвлөгөө тус бүртэй холбоотой хэрэгжүүлэх баримт бичгийн бүрэн жагсаалтыг харуулсан.

²⁰ ОУСК, ЕСБХБ (2009) удирдамж. “Ажилчдын орон байрны журам, стандарт”.

3. НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, БУУРУУЛАХ АРГА ЗАМ

Энэ хэсэгт Шинэ замын барилгын ажил, ашиглалтын улмаас үүсэх байгаль орчин, нийгмийн нөлөөллийг тодорхойлох, үнэлэх аргуудыг дэлгэрэнгүй тусгасан.

Энэхүү үнэлгээнд доорх сэдвүүдийг анхаарч үзсэн:

- Байгалийн нөөцийн ашиглалт, бохирдлоос урьдчилан сэргийлэх;
- Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал;
- Биологийн олон янз байдал;
- Соёлын өв;
- Ажиллах хүч, ажлын нөхцөл;
- Хуримтлагдсан нөлөөлөл.

Дээрх сэдэв нэг бүрийн хувьд үнэлгээнд доорхыг багтаасан байна:

- Суурь нөхцөл;
- Нөлөөлөл;
- Бууруулах арга хэмжээ;
- Хяналт шинжилгээ

3.1 ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Нөлөөллийг бууруулах арга хэмжээний шат дараалал нь ‘ажилчид, нөлөөлөлд өртсөн олон нийт болон байгаль орчинд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг урьдчилан тооцоолж, урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэх боломжгүй бол бууруулах, үлдэгдэл нөлөөлөл үлдэх тохиолдолд нөхөн төлбөр олгож, дүйцүүлэн хамгаалах’²¹ гэсэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга юм. Нөлөөллийг бууруулах хүлээн зөвшөөрөгдсөн хувилбар нь өөр өөр байх ба зохих журмын дагуу нөлөөллийг бууруулах, залруулах, засах, нөхөн сэргээх ажлууд багтана. Тус үнэлгээ нь:

- ОТ компанийн БОННУ-ний үндсэн мэдээлэл болон сүүлийн үеийн судалгааны нэмэлт мэдээллийг ашиглана;
- Шинэ замын барилгын ажил, ашиглалтын улмаас үүдэлтэй нөлөөллийг тодорхойлно;
- Нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсноор үлдэгдэл нөлөөллийг ноцтой биш хэмжээнд байлгана;
- Ноцтой гэж тодорхойлсон үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, хохирлыг барагдуулах аргыг тодорхойлно;
- Нөлөөллийг ууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэхийг баталгаажуулах чиглэлээр явуулах хяналт шалгалтын арга хэмжээг тодорхойлж, төслийн үргэлжлэх хугацааны туршид үр дүнтэй байлгах арга замыг тодорхойлно.

3.1.1 Суурь мэдээлэл

2012 оны 8-р сард гаргасан ОТ БОННУ; 2012 оны Тойруулсан маршрутын замын БОНБНУ²² болон дагалдах баримт бичиг; 2012 оны Түр замын БОНБНУ-ний Нэмэлт үнэлгээ²³ болон 2015 оны Шинэ замын БОНБНУ²⁴-с суурь нөхцөл болон нөлөөллийг бууруулах арга хэмжээний тодорхойлолтыг авсан. Мөн түүнчлэн мэргэжилтнүүд болон биологийн олон янз байдлын зөвлөхүүд биологийн олон янз байдалд үзүүлэх болзошгүй нөлөөллийг үнэлэх, бууруулах арга хэмжээний талаар санал зөвлөмж өгөх зорилгоор 2014 онд Шинэ замын ойр орчмын талбайд үнэлгээ хийсэн.²⁵

²¹ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 1 (2006) Нийгэм, байгаль орчны үнэлгээ болон удирдлагын систем.

²² Nature Firendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” (2012).

²³ Оюу толгойн БОННУ-ний Нэмэлт үнэлгээ (2012), Түр зам болон Тойруулсан маршрут.

²⁴ JEMR ХХК (2014) Цагаан хаднаас Гашуун сухайт хүрэх Засмал замын БОНБНУ-ний суурь судалгаа (2015).

Түр замын коридор нь Шинэ замын коридортой бараг ижил. 2012 оны Түр замын

БОНБНУ-нээс авсан үндсэн мэдээлэл нь 2014 оны БОНБНУ-ний суурь судалгаанаас илүү дэлгэрэнгүй байгаа тул үүнийг ашигласан.

3.1.2 Нөлөөллийн үнэлгээний арга

Тогтвортой байдлыг хадгалахын тулд ОТ компанийн БОННУ-нд нөлөөллийг ангилах чиглэлээр ашигласан аргыг энэхүү санамж бичигт үлдээсэн. Нөлөөллийг Эерэг эсхүл Сөрөг гэж ангилж, доор харуулсны дагуу тодорхойлсон:

- Эерэг: Байгалийн нөөц болон хүлээн авагчид үзүүлэх давуу болон эерэг нөлөөлөл;
- Маш бага (сөрөг): ерөнхийдөө богино хугацааны, хэсэгхэн газрыг хамарсан эсхүл үүсэх магадлал бага нөлөөлөл;
- Бага (сөрөг): богиноос дунд хугацааны, хэсэг газрыг хамарсан эсхүл үүсэх магадлал тун бага нөлөөлөл;
- Дунд зэрэг (сөрөг): ерөнхийдөө дунд хугацааны, хязгаарлагдмал газар нутгийг хамарсан эсхүл үүсэх магадлалтай нөлөөлөл;
- Ноцтой (сөрөг): урт хугацааны, өргөн газар нутгийг хамарсан, үүсэх магадлал нь боломжтойгоос тодорхой хүртэлх нөлөөлөл. Мөн төслийн стандартыг бодитоор зөрчсөн нөлөөллийг сөрөг буюу ноцтой гэж үзнэ.

Нөлөөллийн нэмэлт үнэлгээг уялдаатай байлгахын тулд ОТ БОННУ-нд нөлөөлөл болон нөлөөллийн зэргийг тодорхойлоход ашигласан шалгуур үзүүлэлтийг хэвээр авч ашиглав:

- Үргэлжлэх хугацаа: богино, дунд, урт хугацаа;
- Хамрах хүрээ: хэсэгхэн газрыг хамарсан, хэсэг газрыг хамарсан, хязгаарлагдмал газар нутгийг хамарсан, өргөн газар нутгийг хамарсан;
- Магадлал: боломжгүй, магадлал бага, боломжтой, тодорхой²⁶.

Үлдэгдэл нөлөөллийн зэрэг болон үүнийг төслийн нийт Эерэг нөлөө ахиу үзүүлэх (ЭНАУ) үүрэг амлалтын талаас авч үзсэн асуудлыг тусгасан.

3.1.3 Бууруулах арга хэмжээний шат дараалал

Бууруулах арга хэмжээ нь доорх шат дарааллаар явагдана:

- Нөлөөллөөс зайлсхийх шийдлийг ашиглах;
- Бага нөлөөлөлтэй хувилбарыг сонгох;
- Үлдэгдэл нөлөөллийг удирдан зохицуулахын тулд нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах;
- Томоохон үлдэгдэл нөлөөллийн хохирлыг арилгах эсхүл дүйцүүлэн хамгаалах.

Олон улсын салбарын шилдэг туршлагад ерөнхийдөө нийцсэн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг 2012 оны 8-р сард гаргасан ОТ БОННУ болон сүүлийн үед хийгдсэн мэргэжлийн судалгаанаас авсан.

3.2 БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН АШИГЛАЛТ БА БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Энэ хэсэгт Шинэ замын барилгын ажил, засвар үйлчилгээ, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанявцад үүсэх байгалийн нөөцийн ашиглалт, бохирдлоос үүдэлтэй болзошгүй нөлөөллийн талаар авч үзнэ.

3.2.1 Суурь нөхцөл

Байр зүй, хөрс, геологи

Төслийн талбайн ландшафт, геологи, өнгөн хөрсний дэлгэрэнгүй тодорхойлолтыг ОТ БОННУ²⁷-нд тусгасан.

Хөрс нь ерөнхийдөө Говийн маш сийрэг ургамлан нөмрөгийн (ургамлан нөмрөгийн дундаж үзүүлэлт 8-25%) доор маш муу бүрэлдэн тогтсон.

25 Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

26 Оюу толгой БОННУ (2012) А хэсэг: Танилцуулга, үндэслэл. А3-р бүлэг – Арга зүй.

27 Оюу толгойн БОННУ (2012) В хэсэг: Суурь үнэлгээ. В5 бүлэг – Байр зүй, геологи, өнгөн хөрс.

Хөрсний органик агуулга нь 1%-иас бага, бага зэрэг шүлтлэг. Төслийн талбайн хагас цөлийн цайвар бор хөрсөн дээр үүссэн нарийн ширхэгтэй элсэн давхарга нь хайрга чулуутай нийлээд хөрсийг салхины элэгдлээс хамгаалж, гадаргын органик материалыг хязгаарлагдмал хэмжээнд тогтоон барих гадаргуу үүсгэдэг. Гадаргуугийн хөрсний давхаргыг хөндсөнөөр түүний доор орших хөрс салхины элэгдэл, эвдрэлд өртөж, органик болон тэжээллэг агуулга нь буурч, хөрсний бүтэц алдагдана.

Цагаан хадны суурин болон Гашуун сухайтын хилийн боомтын хооронд орших талбай нь замын барилгын ажлын явцад үүссэн суваг шуудуу, овоолсон шороо, машин тэрэгний хөдөлгөөн, хоёр үндсэн замын хоёр талаар байх талбайг эвдрэлд оруулж буй олон салаа шороон зам зэрэг хүний үйл ажиллагааны улмаас маш их эвдрэлд орсон. Цагаан хадны суурин албан ёсны замгүй бөгөөд суурин газрын эргэн тойронд байрлах олон тооны нүүрсний овоолгоос салхиар дэгдэх нүүрсний тоосжилтын нөлөөлөлд ихээр өртдөг. Таван толгойн нүүрсний уурхайгаас хил рүү нүүрс тээвэрлэдэг Монголын талын ачааны машин Монголын талд ачаагаа буулгахыг шаарддаг тул нүүрсээ Цагаан хаданд буулгадаг. Дараа нь Хятадын зах зээл рүү тээвэрлэлт хийх Хятадын талын машинд нүүрсийг шилжүүлэн ачдаг. Цагаан хадны эргэн тойрны хөрс, усны эх үүсвэрт нүүрсний тоос буусан нь илт ажиглагддаг. Цагаан хадны суурин болон Гашуун сухайтын замын дагуу үйлдвэрлэлийн болон ахуйн эх үүсвэрээс үүдэлтэй

хөрсний бохирдол бүртгэгдсэн.


2014 оны БОНБНУ-ний суурь судалгааны хүрээнд авсан хөрсний дээжид хийсэн шинжилгээгээр Шинэ замын маршрутын дагуух хөрс нь салхи, усны элэгдэл, бохирдолтод өртөмхий болох нь харагдаж байна. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хөрсний дээд давхаргыг нягтруулснаар механик шинж чанарыг нь алдагдуулдаг. Хөрс сэвсгэр болж, салхины элэгдэл эвдрэлд орсноор гадаргын урсац нэмэгдэх үед хөрс зөөгдөнө. Тухайлбал, 2014 оны судалгаагаар дараах нөхцөл байдлыг илрүүлсэн:

- Цагаан хад, Гашуун сухайт, тэдгээрийн орчмын хөрс нүүрсний тоосжилт, хаягдлаар бохирдож, салхины эвдрэлд маш их өртсөн;
- Баруун тогоо уулын орчмын хөрс бохирдоогүй, салхины элэгдэл, эвдрэлд өртөөгүй боловч гадаргын урсацын элэгдэл, эвдрэл ажиглагдсан;
- Шинэ замын маршрутын дагуу замгүй газраар явсан машин тэрэгний хөдөлгөөний улмаас хөрс ноцтой эвдрэлд орж, 30 см гүн ховил үүссэн байна.

Замын маршрутын дагуух хөрсний эвдрэлийг 2-р зурагт харуулсан бөгөөд эндэхийн хөрс нэг чигийн дагуу усны элэгдэл, салхины элэгдэл болон хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөнийг харуулж байна.

Шинэ замын маршрутын дагуух хэсгээс авсан хөрсний дээжид хром, хар тугалга, кадми, никель, цайр зэрэг хүнд металлийн агуулгыг шинжилсэн бөгөөд шинжилгээний хариугаар бүх металлийн агуулга нь Монгол Улсын стандартын (MNS 5850:2008) түвшингээс бага байгааг харуулсан.

Зураг 2: Шинэ замын зурвасын дагуух хөрсний элэгдэл, эвдрэл



Гүний ус болон гадаргын түр урсац

Дэд бүтцийн зурвасын гидрологи, гидрогеологийн нөхцөл нь Оюу толгойн уурхайн лицензийн талбай орчмынхтой ижил төстэй бөгөөд ширүүн борооны дараа гадаргын усны түр урсац үүсэж, богино хугацаанд урсаж өнгөрдөг.

Шинэ зам нь Цагаан хад болон Гашуун сухайтын хооронд орших дөрвөн жижиг түр урсацыг дайран өнгөрөх ба тэдгээрийн хоёр нь төлөвлөсөн шинэ замын маршрутыг дайран урсаж өнгөрдөг байна. Дээрх урсацууд нь замын хойд хэсгийн баруун, зүүн талд орших Баруун тогоо овоо (1,136.9 м) болон Зүүн тогоо овоо (1119.4 м) уулнаас, мөн замын урд хэсэгт орших Монгол Улсын хил орчмын уулсын бэл хормойгоос эх авдаг.

2014 онд хийгдсэн БОНБНУ-ний суурь судалгааны явцад судалгааны талбайд гурван худаг, хоёр цооног илрүүлсэн. Нэг худаг, нэг цооногоос авсан химийн шинжилгээгээр ундны усны MNS 900:2010 стандартын шаардлагыг хангаж байсан. Усны өнгө, тунадасжилт нь уухад тохирохгүй болохыг гэрчилж байна. Шинэ замын орчимд малчны худаг байхгүй.

Дуу чимээ

2011 оны 3-р сард дуу чимээний суурь түвшинг тогтоох зорилгоор Оюу толгойгоос Гашуун сухайт явах зам дагуух тээврийн хэрэгслийн дуу чимээний судалгааг явуулсан²⁸. Өдрийн цагийн дуу чимээний дундаж түвшин 66 dB(A) - 77 dB(A) байна. Шөнийн цагийн дуу чимээний дундаж түвшин 25 dB(A) - 56 dB(A) байна.

Гашуун сухайтын төслийн талбайд тэмдэглэгдсэн шөнийн цагийн дуу шуугианы түвшин нь төслийн стандарт буюу 55 dB(A) хязгаараас бага байсан хэдий ч Цагаан хадны шөнийн цагийн дуу шуугианы түвшин нь төслийн стандартаас хэтэрсэн. Цагаан хад болон Гашуун сухайтын өдрийн цагийн дуу шуугианы түвшин нь төслийн стандартаас тус тус хэтэрсэн байна.

Агаарын чанар болон хүлэмжийн хийн ялгаруулалт

2014 онд хийгдсэн БОНБНУ-ний суурь судалгаагаар Шинэ замын зурвасын дагуу долоон цэгт хээрийн хэмжилт хийсэн. Нэг цэгт MNS 4585:2007 стандартад заасан хүхрийн давхар исэл болон азотын давхар ислийн дээд хязгаараас хэтэрсэн үзүүлэлттэй гарсан. Шинэ замын маршрут нь ерөнхийдөө маш их тоосжилттой, PM2.5 болон PM10 тоосонцрын хэмжээ өндөр гарсан нь замгүй газраар явах, хөрсний элэгдэл, нүүрсний тоосжилт, хур тунадас бага ордог зэрэгтэй холбоотой.

Хүлэмжийн хийн эх үүсвэрийн бүртгэл судалгаа болон хүлэмжийн хийн ялгаруулалтын анхан шатны тооцооллыг төслийн БОННУ²⁹-д зориулан гаргасан бөгөөд Оюу толгой Гашуун сухайтын хоорондох улсын чанартай замын барилгын ажилтай холбоотойгоор үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллыг мөн тусгасан. Шаардлагатай бол тус бүртгэл судалгааг шинэчлэн хийж, Шинэ замын

барилгын ажилтай холбоотойгоор үүсэх хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцооллыг тусгаж болно. Энэхүү тайланд хүлэмжийн хийн талаар дахин авч үзээгүй.

3.2.2 Нөлөөлөл

Байр зүй, хөрс, геологи

Шинэ замын барилгын ажлаас үүдэлтэй нөлөөлөлд доорх багтана:

- Тээврийн хэрэгсэл явах зам, төслийн талбайн цэвэрлэгээ, одоо байгаа карьерыг ахин ашиглах эсвэл шинээр байгуулах, ухаж гаргасан материалыг овоолох зэргээс үүдэлтэй өнгөн хөрсний элэгдэл эвдрэл;
- Шатахуун болон бусад аюултай бодис асгарсны улмаас өнгөн хөрс бохирдох;
- Төслийн талбайн ажилтан, төслийн талбайн тээврийн хэрэгсэл болон хилийн боомт руу явах төслийн талбайн бус тээврийн хэрэгслээс хаягдах хог хаягдал;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, талбайн цэвэрлэгээ, карьерын малталт, зам барилгын материалын овоолгоос үүсэх тоосжилт.

²⁸ Оюу толгойн БОННУ (2012). В хэсэг: Суурь үнэлгээ. В4-р бүлэг: Дуу чимээ, доргилт.

²⁹ Оюу толгойн БОННУ (2012). А хэсэг: Танилцуулга, үндэслэл. С2-р бүлэг – Уур амьсгал, агаарын чанар.

Элс, хайрганы карьер нь ГБДЦГ-ын Б хэсгийн гадна гэхдээ түүний Орчны бүс дотор байрлах бөгөөд БОННУ-ний хүрээнд зөвшөөрөл авах шаардлагатай.

Гүний ус болон гадаргын түр урсац

Барилгын үйл ажиллагаанаас үүсэх хамгийн эхний болзошгүй нөлөөлөл нь гадаргын түр урсацаар хөрс зөөгдсөний улмаас усны чанар муудах мөн нүүрс устөрөгчийн материал асгарсны улмаас гадаргын түр урсац бохирдож болзошгүй.

Шинэ зам түр урсацыг огтолж буй хэсгүүдэд байгалийн урсацын горим өөрчлөгдсөнөөр тухайн урсацаар тэжээгдэж буй хайлаас зэрэг ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлнө. Өөрөөр хэлбэл урсацын доод хэсэгт гадаргын элэгдэл эвдрэл явагдсанаар урсацын чиглэл өөрчлөгдсөнөөс үүдэлтэйгээр ургамлан нөмрөгт очих усны урсац буурахад хүрнэ.

Дуу чимээ болон агаарын чанар

Замын барилгын ажлын явцад хөдөлгөөнт тоног төхөөрөмж, асфальтын үйлдвэр, бутлуурыг ашигласнаар дуу чимээ ихсэж, зэрлэг ан амьтад тухайн талбайд нэвтрэх нь багасна. Зам барилгын ажил хийгдэх талбай нь нүүрс тээврийн томоохон замд ойр орших бөгөөд одоогийн үйл ажиллагаа нь нүүдлийн туурайтан амьтдыг үргээхэд нөлөөлж буй тул зам барилгын ажлаас үүсэх дуу чимээний нэмэлт нөлөөлөл тийм ч их биш байна.

Зам ашиглалтаас үүдэлтэй дуу чимээ болон агаарын чанарт тухайн замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал ихээр нөлөөлдөг.

ТЭЗҮ-ийн хүрээнд явуулсан замын хөдөлгөөний судалгаанд нүүрс тээврийн хөдөлгөөн, Оюу толгойн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, төлөвлөсөн төмөр замын байгууламж болон нийтийн зориулалттай тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалалд орох өөрчлөлт зэрэг хэд хэдэн таамаглалд үндэслэн ирээдүйн замын хөдөлгөөний ачааллыг загварчлан гаргасан. Урьдчилан тооцоолсон замын хөдөлгөөний ачааллыг дор үзүүлсэн 1-р хүснэгтэд³⁰ харуулав.

Тээврийн хэрэгсэл, ялангуяа хүнд даацын тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр Цагаан хадны оршин суугчид болон замын маршрутын дагуух зэрлэг ан амьтад зэрэг орон нутгийн хүлээн авагчдад агаарын чанар муудах, дуу чимээ ихсэх зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Хүснэгт 1: Ашиглалтын эхний жил болон 2034 оны замын хөдөлгөөний тооцоот ачааллын загварчлал

Жил	Хоногт явах хүнд даацын тээврийн хэрэгслийн тоо	Хоногт явах зорчигч тээврийн хэрэгслийн тоо	Хоногт явах тээврийн хэрэгслийн нийт тоо
Ашиглалтын эхний жил (2014 ТЭЗҮ-д)	597	47	644
2034 он	1092	596	1688

Шинэ замын барилгын ажил нь уг маршрутын дагуу тоосжилт хэдийнэ үүсчихээд байгаа орчинд нэмэлт тоосжилт үүсгэнэ. Зам ашиглалтад орсноор замгүй газраар явах нь багасаж, хатуу хучилттай замаар явах тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэнэ. Ингэснээр тухайн замын зурвасаар дайран өнгөрч буй тээврийн хэрэгслүүд тоос дэгдээх нь багасах тул хэтдээ эерэг нөлөөлөл үзүүлнэ.

³⁰ Замын хөдөлгөөний үндсэн ачааллыг Авто замын хяналт, эрдэм шинижлгээ, судалгааны төв болон Гашуун сухайтын хилийн боомтын мэдээллээс тооцоолон гаргасан.

3.2.3 Бууруулах арга хэмжээ

Дор дурдсан БОНУТ болон Оюу толгойн дотоод журмууд нь дээрх 3.2.2-р зүйлд дурдсан болзошгүй нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгасан:

Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөөнүүд

- Агаар мандалд ялгарах хүлэмжийн хийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-E2-

PLN-0001)-нд тоосжилтыг хянах журмыг тусгасан.

- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-1001). Уг төлөвлөгөөнд дуу шуугианы түвшин, зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийн асуудлыг авч үзсэн.
- Дуу чимээ, доргилтын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е6-PLN-0001) -нд замын хөдөлгөөний дуу шуугианы түвшин, зэрлэг ан амьтдад үзүүлэх нөлөөллийг хянах аргыг тусгасан.
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PLN-001 болон Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-0001)-нд тээврийн хэрэгсэл замгүй газраар явах болон дуу чимээг хянах журмыг тусгасан.
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е10-PLN-0001)-нд цооног өрөмдөх журам, нөлөөллийн үнэлгээ, бууруулах арга хэмжээ, зам барилгын ажлын журмыг тоймлон оруулсан.

Журмууд

- Газар хөндөх зөвшөөрлийн журамд (ОТ-10-Е-PRC-0001) газар хөндөх үйл ажиллагаатай холбоотой стандарт, журмыг тогтоож өгсөн бөгөөд Газар хөндөх зөвшөөрлийн системийг ашигласнаар эдгээр стандарт, журмыг чанд хэрэгжүүлдэг. Уг журам нь мэдрэмтгий хүлээн авагчдыг тодорхойлж, газар хөндөх ажилд хамаарах тодорхой үйл ажиллагаанаас (ил уурхай, карьерын үйл ажиллагаа) үүсэх тоосжилтыг хянахад ашиглагддаг.
- Аюултай материалтай ажиллах журамд (ОТ-10-Е5-PRC-0001-Е) аюултай материалтай ажиллах, хадгалахдаа асгаралтаас сэргийлэх шаардлагуудыг тусгасан.
- Нөхөн сэргээлтийн журамд (ОТ-10-Е9-PRC-0002-Е) зам, жим, карьерын нөхөн сэргээлтийг хийх алхмуудыг тусгасан.
- Асгаралтын хариу арга хэмжээний журам (ОТ-10-Е5-PRC-0002-Е)-д аюултай бодис асгарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээг тусгасан бөгөөд ингэснээр асгаралтын улмаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна.
- Өнгөн хөрстэй харьцах журам (ОТ-10-Е9-PRC-0001-Е)-д хөрс хуулалт, овоолго, хяналт шинжилгээний үйл ажиллагаа зэрэг өнгөн хөрсний үр ашигтай удирдлагад тавигдах шаардлагуудыг тоймлон оруулсан.

Байр зүй, хөрс, геологи

ГБДЦГ-ын Б хэсгийн Орчны бүс дотор, ГБДЦГ-ын хилээс баруун тийш орших Хязгаарлалтын бүсээс 3 км зайд 20 орчим карьер байдаг. Эдгээр карьерын заримд нь техникийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд БОНБНУ батлагдсан тохиолдолд эдгээр хагас нөхөн сэргээлт хийсэн карьерыг төсөлд шаардлагатай материалыг ханган нийлүүлэхэд ашиглахаар төлөвлөж байна.

Ажлын хамрах хүрээг хянаж үзээд шаардлагагүй гэж үзснээс бусад тохиолдолд “Оюу толгой” компанийн Байгаль орчны хэлтэс газар шорооны ажил хийх гэрээт гүйцэтгэгч

нарт Өнгөн хөрстэй харьцах журам боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага тавьдаг. Үүнийг Газар хөндөх зөвшөөрлийн (ГХЗ) дагуу удирдан зохицуулна. Гүйцэтгэгчийн боловсруулах журамд доорх зүйлс багтах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй:

- Төлөвлөлт;
- Өнгөн хөрс хуулалт;
- Хадгалалт;
- Элэгдэл, тоосжилтыг хянах;
- Өнгөн хөрсийг дахин ашиглах (нөхөн сэргээлтэд).

Гүйцэтгэгчийн боловсруулсан журмыг ОТ компани батлах бөгөөд Өнгөн хөрстэй харьцах журамд дэлгэрэнгүй заасан шаардлагуудад нийцсэн байх ёстой.

Хөрсөнд зайлшгүй үзүүлэх нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээнд доорх зүйлс багтана:

- Хатуу хучилтгүй зам, карьерын талбай, материалын овоолгын тоосыг дарахад усны машин ашиглах;
- Барилгын ажлын оргил үед замын чиглэлийн дагуу үүссэн хог, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлыг долоо хоногт гурван удаа шалгаж, зайлуулах.

Гүний ус болон гадаргын түр урсац

Шинэ замын зураг төслийн хүрээнд ОТ компани Цагаан хаднаас урагш ойролцоогоор 1.5 км-т орших хойд хэсгийн түр урсац дээр үер өнгөрөөх байгууламж барина. Энэ нь замын дагуу байрласан 1 м диаметртэй 16 ширхэг ус гаргуураас бүрдэнэ. Гашуун сухайтын хилийн боомтоос хойш 2 км-т байрлах өмнөд хэсгийн томоохон түр урсац дээр 2x2 хэмжээтэй тэгш өнцөгт огтлолтой ус гаргуурыг замын зураг төсөлд тусгана.

Доорх 2-р хүснэгтэд Үйл ажиллагааны удирдлагын төлөвлөгөө, Хөрөнгө оруулалтын гэрээ болон бусад дагалдах баримт бичгүүдэд заасан Шинэ замаас гардаргын усны урсацад үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээг тусгасан.

Хүснэгт 2: Усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах

Баримт бичиг	Дугаар	Бууруулах арга хэмжээ
Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө ³¹	WR16	Төслийн барилга байгууламж, дэд бүтэц (Төслийн зам г.м) гадаргын түр урсац эсхүл голын хуурай сайрыг хөндлөн гарах тохиолдолд гарам эсхүл ус гаргуур барина. Ус гаргуурыг ашиглах бол үерийн урсацыг хангалттай өнгөрөөх, ус гаргуурын дээд болон доод хэсэгт гадаргын элэгдэл эвдрэл үүсгэхгүйн тулд дээрх байршлуудад тус тусад нь үнэлгээ хийж, зураг төслийг гарган, угсарна. Голын эхэнд байх ус гаргуурыг 100 жилд 1 тохиолдох үерийн урсацыг өнгөрөөхөөр, харин бусад хэсэгт 10 жилд 1

		тохиолдох үерийн урсацыг өнгөрөөхөөр тооцно. Гэнэтийн үер болж болзошгүй түр урсацын ойролцоо газар хөндөхөөс зайлсхийснээр элэгдэл, эвдрэл үүсэх эрсдэлээс сэргийлнэ. Элэгдэл, эвдрэл үүсэх эрсдэлийг бууруулахын тулд хөндөгдөж эвдэрсэн эргийг нөхөн сэргээнэ.
	WR15	Ус хангамжийн түр цооногийг ашиглахын өмнө цооног тус бүрээр үнэлгээ хийж усны түвшинд нөлөө үзүүлэх талбайн хэмжээд нь гуравдагч талын ашигладаг эсхүл зэрлэг ан амьтдын ундаалдаг булаг шанд, цооног байгаа эсэхийг шалгана.
	WR04	Ус гаргах цооног өрөмдөхдөө: (i) усан суурьтай полимер өрөмдлөгийн шавар ашиглана; (ii) хэмхдэс болон илүүдэл шаврыг тухайн орчимд байгуулсан шаврын цөөрөмд цуглуулна; (iii) ажлыг бүрэн дуусгасны дараа шаврын цөөрмийг ууршуулж, хучилт хийх бөгөөд гидрогеологийн нэгжүүдтэй гидравлик холбоотой байх тохиолдолд талбайг нөхөн сэргээх Нөлөөлөл бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Хөрөнгө оруулалт	6.19.2-р зүйл	ОТ компани Хөрөнгө оруулалтын гэрээгээр ундны ус болон малын ус хангамжийн эх үүсвэрийн тоо хэмжээ, чанарыг одоогийн байгаа түвшнээс бууруулахгүй байх үүрэг амлалт хүлээсэн (Хөрөнгө оруулалтын гэрээ).
Биологийн олон янз байдлын үнэлгээ ³²		Замын доогуур гарсан урсацыг задгайруулж, байгалийн урсацтай дөхүү болгосон тохиолдолд урсгалын доод хэсэгт орших ургамалд үзүүлэх нөлөөлөл багасна. Төлөвлөсөн ус гаргуураас гарч буй урсацыг байгалийн урсацтай дөхүү болгох хайрган дэвсгэр болон ус задгайруулах шуудуу зэрэг нэмэлт байгууламж хийх асуудлыг мөн харгалзан үзэх нь зүйтэй. Ус зайлуулах хоолойн дам нөлөөллөөс сэргийлэхийн тулд ус гаргууруудыг талбайн налуугаас хамааран зохих зайд байрлуулна.

Дуу чимээ

Зэрлэг ан амьтдад үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах зорилгоор төслийн стандартаас хэтэрсэн дуу чимээ гаргах магадлалтай үйл ажиллагааг доорх бууруулах арга хэмжээгээр дамжуулан удирдан зохицуулна:³³

- Дуу чимээ ихтэй барилгын ажлыг зөвхөн ажлын цагаар гүйцэтгэх;
- Булаг шанд болон зэрлэг ан амьтдын цуглардаг цэгээс 500 метрийн зайд дуу чимээ ихтэй, суурин тоног төхөөрөмж байрлуулахгүй байх;

³¹ Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-E10-PLN-0001)

³² Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй

өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

33 Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-1001)
Хавсралт D.

- Онцгой дуу чимээ ихтэй тоног төхөөрөмжид дуу чимээний хаалт, дуу намсгагч, дуу тусгаарлагч, бүрхүүл зэрэг дуу чимээ багасгах хэрэгсэл ашиглах;
- Төслийн стандартын хамгийн дээд хязгаарт хүрч болзошгүй онцгой дуу чимээ ихтэй тоног төхөөрөмжийг дуу чимээний хаалт, дуу намсгагч, дуу тусгаарлагч, бүрхүүл зэрэг дуу чимээ багасгах хэрэгслээр тоноглоно;
- Шинэ замын хурдны дээд хязгаар 80км/цаг байна.

Агаарын чанар

Тоосжилт үүсгэх ажлуудыг ГХЗ-д заасан (олгосны дараа) нөхцөл, Агаар мандалд ялгаруулах хүлэмжийн хийний удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е2-PLN-0001), Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PLN-0001), Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-0001)-нд заасан нөлөөлөл бууруулах арга хэмжээний дагуу удирдаж хянана.

3.2.4 Үлдэгдэл нөлөөлөл

Шинэ зам нь байнгын байгууламж бөгөөд албан ёсны засмал замын нэгдсэн систем нь замгүй газраар явах, түүнээс улбаатай тоосжилт, хөрсөнд үзүүлэх нөлөөллийг ихээхэн хэмжээгээр бууруулна. Шинэ зам орчмын газрын гадаргуу болон хөрсөнд үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг **эерэг** байна гэж үзсэн.

Төслийн талбай дах барилгын тоног төхөөрөмж, машин техникийн дуу шуугианы түвшинг Дуу чимээ, доргилтын удирдлагын төлөвлөгөө болон дээр дурдсан нөлөөлөл бууруулах нэмэлт арга хэмжээний дагуу удирдан зохицуулна. Зэрлэг ан амьтдад үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг **маш бага** байна гэж үзсэн.

Шинэ зам нь ландшафтын байнгын байгууламж болно. Засмал зам нь уг замыг ашиглан Гашуун сухайтын хилээр нэвтрэх ОТ компанийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон төслийн бус тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулна. Шинэ зам нь одоогийн байгаа замын зурваст баригдах тул тээврийн хэрэгслийн дуу чимээний үлдэгдэл нөлөөлөл, замын дагуу үүсэх хог хаягдал, бохирдол нь замын маршрутын дагуу орших талбайд **маш бага** нөлөөлөл үзүүлнэ гэж үзсэн.

Гадаргын усанд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь барилгын ажлын үе шатанд гадаргын түр урсацын ойр орчимд ажил гүйцэтгэх үед хамгийн их байна. Ийм төрлийн нөлөөлөл шинж чанарын хувьд богино хугацааны байх ба зам ашиглалтад орсны дараа нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тохиолдолд гадаргын түр урсацад үзүүлэх урт хугацааны нөлөөлөл **маш бага** байна гэж үзсэн .

3.2.5 Хяналт шинжилгээ

Агаарын чанарын хяналтын төлөвлөгөө (ОТ-10-Е2-PLN-0002-Е) -ний дагуу зам барилгын ажлын явцад тоосжилтын хяналт шинжилгээ хийхийг шаарддаг.

Дуу шуугианы шинжилгээ, хяналтын журам (ОТ-10-Е6-PRC-0001)-д дуу чимээний хяналт шинжилгээний арга зүй, хэмжилт хийх байршил, давтамж, дуу чимээний удирдлагын арга хэмжээг тодорхойлсон.

Усны хяналт шинжилгээний төлөвлөгөө (ОТ-10-Е10-PLN-002-Е)-нд заасны дагуу Оюу толгой - Гашуун сухайтын зам дагуух хяналт шинжилгээний цооногт гүний усны хяналт шинжилгээг улирал тутам хийх шаардлагатай. Зам барилгын ажлын улмаас үүссэн гадаргын элэгдэл, эвдрэлийн чанарын үнэлгээг гаргах зорилгоор томоохон ус гаргууруудыг нүдээр шалгаж, зургийг нь авна. Мөн түүнчлэн малчны худгийн нөхцөл байдалд жил тутам шалгалт явуулж, хөрсний элэгдэл, зөөгдлийн улмаас сөрөг нөлөөлөл үүссэн эсэхийг тогтооно.

Шинэ замын барилгын ажлын гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг хянаж, ГХЗ болон холбогдох Удирдлагын төлөвлөгөөний нөхцөлд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

Барилгын ажлын дараа уугуул ургамлын нөмрөг, усан орчин, зэрлэг ан амьтдын амьдрах орчин, малын бэлчээр зэрэг газрын эцсийн ашиглалтыг өмнөх ашиглалтын түвшинд хүргэх үүднээс ил уурхай/карьер, ашиглагдахгүй замд Нөхөн сэргээлтийн журам (ОТ-10-Е9-PRC-0002-Е) – ыг хэрэгжүүлнэ.

3.3 ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

3.3.1 Суурь нөхцөл

2012 оны 2-р улиралд Цагаан хадны суурин нь Ханбогд сумын Хайрхан баг болж зохион байгуулагдсан. Ойролцоогоор 100 орчим хүн Цагаан хаданд амьдардаг бөгөөд 1200- 2000 хүн тус талбайгаар зорчдогийн ихэнх нь нүүрсний машины жолооч нар байна³⁴.

Цагаан хадаар дамжин өнгөрөх хүний тоо 2013 онд нүүрсний эрэлт буурснаас хойш тасралтгүй буурсаар байна.

2015 онд Цагаан хад орчмын шатахуун түгээгүүр болон компаниудад газар ашиглах 5 зөвшөөрөл олгосон. Ус хангамжийг Энержи ресурсын өрмийн худаг болон Цагаан хаднаас зүүн урагш 16 км-т орших “Дөрвөлжин тээг”-ийн худгаас авдаг. Тус баг эрчим хүчний хангамжаа Хятадаас авдаг ч Цагаан хадны бүх айл өрх, аж ахуйн нэгж өөрийн гэсэн бага оврын цахилгаан үүсгүүр ашигладаг.

3.3.2 Нөлөөлөл

Шинэ замын барилгын ажил болон ашиглалтаас малчид болон Цагаан хадны оршин суугчдад үзүүлж болзошгүй нөлөөлөл:

- Замын хажууд орших кэмпүүдийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоос, дуу чимээ;
- Замын барилгын ажилд ус ашигласнаас малчдын гар худагт үзүүлэх нөлөөлөл;
- Замын хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор мал сүрэг машинд дайруулах (тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал нэмэгдэхгүй, зөвхөн үндсэн зам руу шилжинэ).

Шинэ замын ашиглалтаас үүсэх нөлөөлөл нь ЭР-ийн төлбөртэй замын урт хугацааны ашиглалттай ижил төстэй бөгөөд тэдгээрийг дурдвал:

- Замын осол гарах эрсдэл нэмэгдсэнээр шатахуун, ачаа асгарах;
- Тээврийн хэрэгслүүд хоорондоо эсвэл явган зорчигчидтой мөргөлдөх эрсдэл нэмэгдсэнээр гэмтэж бэртэх, амь насаа алдах;
- Зэрлэг ан амьтан, мал дайрах эрсдэл нэмэгдэх;
- Хүнд даацын тээврийн хэрэгсэл явах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэнээр орон нутгийн зам элэгдэж, эвдрэх;
- Зэрлэг ан амьтдын шилжилт хөдөлгөөн хязгаарлагдах.

Тус газар нутгийг зам тээвэрт хэдийнэ ашиглаж байгаа тул дээрх нөлөөлөл хамгийн бага түвшинд байна гэж үзсэн.

3.3.3 Бууруулах арга хэмжээ

Үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны нөлөөллийг бууруулах зорилгоор доорх арга хэмжээг боловсруулсан:

- Замын маршрут, малчдын өвөлжөө хаваржаа болон орон нутгийн барилга байгууламжийн хооронд 500 метрээс багагүй зайтай байх;
- ОТ компанийн тээврийн хэрэгслийг зөвхөн тогтоосон маршрутаар зорчуулах (замгүй газраар явахыг зөвшөөрөхгүй);
- Зам барилгын үйл ажиллагаанаас малчдын худаг, байгалийн булаг шандны усны чанарт сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, нөлөөлөл үүссэн тохиолдолд Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөөнд заасны дагуу нөлөөлөл бууруулах зохих арга хэмжээг авах.

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлын чиглэлээр доорх бууруулах арга хэмжээг боловсруулсан:

- Бүх тээврийн хэрэгсэл, ачаа тээврийн үйл ажиллагаанд хууль, эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөх нь хамгийн наад захын шаардлага гэж үзэн ОТ-с аюулгүй ажиллагааны зохих стандартыг мөрдүүлэх. Ур чадварын шалгалтад

тогтмол хамрагдах ОТ компанийн жолооч нарт жолоодлогын аюулгүй ажиллагааны сургалт явуулах шаардлагатай;

- Замын хөдөлгөөний тооцоот ачааллыг аюулгүй нэвтрүүлэх, замаар зорчих ачааны машины хэмжээнд тохирсон байхаар тооцож замын зураг төслийг гаргах. ОТ компани орон нутгийн захиргаа болон бусад зам ашиглагч нартай хамтран зам болон замын гадаргууг шалгаж орон нутгийн ард иргэдийн аюулгүй байдлын шаардагд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.
- ОТ компанийн ослын үед авах арга хэмжээний журам нь хамгийн наад зах нь хууль, эрх зүйн шаардлагуудыг бүрэн хангасан байх ба орон нутгийн захиргааны оролцоог хангаж, олон нийтэд тайлбарлан таниулах хөтөлбөрийг тусгасан байна;
- Тэсэлгээний ажил нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна. шаардлагатай бол хөрш зэргэлдээ орших оршин суугчдад тэсэлгээний талаар мэдэгдэнэ.

³⁴ Ханбогд сумын Засаг даргын тамгын газартай харилцаа холбоотой байх.

Цагаан хад

Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх улсын чанартай зам Цагаан хадыг дайран өнгөрдөг бол санал болгож буй Шинэ зам уг суурингийн захаас эхэлнэ. ОТ компани шилжин ирэх хөдөлгөөний эрсдэлд оршиж буй уг сууринг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний асуудлаар орон нутгийн захиргаатай хамтран ажиллана. Хүн амын шилжилт хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө, Орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын төлөвлөгөө нь ОТ компанийн зүгээс хүн амын шилжилт хөдөлгөөнийг шийдэхээр авч хэрэгжүүлэх санал санаачлага, үйл ажиллагааг^{35, 36} тусгасан.

3.3.4 Үлдэгдэл нөлөөлөл

Цагаан хадны суурингийн байгаль орчин, нийгмийн нөхцөл байдлыг нүүрсний овоолго болон тус суурин газраар дайран өнгөрч буй ачаа тээврийн үйл ажиллагаагаар тодорхойлно. Нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр Цагаан хадны Шинэ замын барилгын ажил, ашиглалтын явцад үүсэх үлдэгдэл нөлөөллийг **бага** байна гэж үзсэн.

3.3.5 Хяналт шинжилгээ

Шинэ замын барилгын ажлын гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг хянаж, ГХЗ болон холбогдох Удирдлагын төлөвлөгөөний нөхцөлд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Говийн бага дархан цаазат газар (ГБДЦГ)

ГБДЦГ нь Оюу толгой уурхайн лицензийн талбайгаас баруун урагш ойролцоогоор 36 км (А хэсэг), зүүн урагш 70 км зайд орших (Б хэсэг) хоёр тусдаа хэсгээс бүрдэнэ. ГБДЦГ нь Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд сум, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нийт 1,839.176 га талбайг эзлэн оршино. Баруун талд орших А хэсэг нь байгаль хамгаалагч болон хил хамгаалагчдыг эс тооцвол эл хуль байдаг бол зүүн талд орших Б хэсэгт малчид жилийн дөрвөн улиралд нүүдэллэн амьдардаг.

ГБДЦГ-ыг 1993 онд (УИХ-ын 83-р тогтоолоор) зүүн өмнөд Говийн бүсийн эко системийн төлөөлөл болгон тусгай хамгаалалтад авсан бөгөөд тухайн үед малын хөл, ан агнуурын үйл ажиллагаанд харьцангуй бага өртсөн байжээ. Хүмүүсийн ам дамжсан яриагаар ГБДЦГ-ын А болон Б хэсгийн дунд орших зурвас талбай нь тэр үед газрын тосны хайгуулын лиценз олгогдсон байжээ.

ГБДЦГ нь Байгаль хамгаалах олон улсын холбооны ангиллаар Ib буюу дархан цаазат газрын ангилалд багтсан. Энэхүү ангилал нь “*өөрчлөгдөөгүй эсхүл бага зэрэг өөрчлөгдсөн, байгалийн унаган төрх, үр нөлөөгөө хадгалж үлдсэн, байнгын эсхүл томоохон суурин газар байхгүй, унаган төрх байдлыг нь хадгалан үлдээх зорилгоор хамгаалалтад авсан хуурай газар далай тэнгисийн томоохон талбай*”-д хамаарна.

ГБДЦГ нь хадан цохио, элсэн манхан, эртний тэнгисийн ёроол, өргөн уудам тал, булаг шанд бүхий баянбүрдээс тогтох бөгөөд эдгээр нь хулан, хар сүүлт зээр, аргаль, янгир зэрэг амьтны амьдрах орчин болдог.

ГБДЦГ-т дөрвөн бүсийг тогтоосон бөгөөд үүнд:

- Орчны бүс;
- Хязгаарлалтын бүс;
- Хамгаалалтын бүс;
- Онгон бүс.

Шинэ зам нь бүхэлдээ ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүсэд, харин хайрганы карьер нь ГБДЦГ-ын Б хэсгийн Орчны бүсэд байрлана.

³⁵ Хүн амын шилжилт хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0004)

³⁶ Орон нутгийн ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0001)

2004 онд замын зурвасын БОННУ-ний хүрээнд хийсэн нийгэм–эдийн засгийн судалгаагаар ГБДЦГ-ын Б хэсэгт ойролцоогоор 4000 гаруй мал бүхий, найман малчин өрхийг тогтоосон³⁷. Дээрх малчин өрхүүд ГБДЦГ-ыг байгуулахаас өмнө тус бүс нутагт амьдарч ирсэн бөгөөд тэднийг нүүлгэн шилжүүлээгүй.

2006 онд ГБДЦГ-ын захиргааг Ханбогд суманд байгуулсан. Тус захиргаанд 14 хүн ажилладгаас ес нь байгаль хамгаалагч (хамгаалалттай газар нутагт малаа бэлчээрлүүлж, хууль бус ан агнууртай тэмцэх эргүүл хийдэг малчид). ГБДЦГ-ын хэмжээтэй харьцуулахад Байгаль хамгаалагчдын тоо цөөн бөгөөд ОТ компани Биологийн олон янз байдлын стратеги, төлөвлөгөөнийхөө дагуу ГБДЦГ-ын захиргаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж ирсэн.

ОТ компани:

- ГБДЦГ-ын хамгаалалтын захиргаа, орон нутаг болон бусад үндсэн оролцогч талуудтай зөвшилцсөн;
- Төслийн байгаль орчны удирдлага, нөлөөллийг бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үүрэг амлалтыг Тусгай хамгаалалттай газрын удирдлагын төлөвлөгөөнд заасан менежментийн зорилтуудтай нийцүүлсэн;
- ОТ компанийн дүйцүүлэн хамгаалах удирдлагын стратегид тусгай хамгаалалттай газрыг чандлан хамгаалах арга хэмжээг тусгасан³⁸.

Чухал амьдрах орчин

Оюу толгой төслийн нөлөөллийн бүсийг шууд болон шууд бус нөлөөлөл үүсэх газар нутаг гэж тодорхойлсон³⁹. Нөлөөллийн бүсэд орших эн тэргүүнд хамгаалах биологийн олон янз байдал гэдэгт Зээлдүүлэгчдийн тодорхойлсноор Нэн чухал амьдрах орчныг (ОУСК PS6, ЕСБХБ PR6) бүрдүүлж буй төрөл зүйл, амьдрах орчныг авч үзсэн бөгөөд Рио тинтогийн Биологийн олон янз байдалд эерэг нөлөө ахиу үзүүлэх төлөвлөгөөнд тодорхойлсноор эн тэргүүнд авч үзэх асуудал гэж үзсэн (Рио Тинто 2011).

Төсөлтэй холбоотой нэн чухал амьдрах орчны хамрах хүрээ, чанарын шалгуур болон нэн чухал амьдрах орчныг тодорхойлох зорилгоор ОТ БОННУ-ний суурь судалгааны хүрээнд олон улсын биологийн олон янз байдлын мэргэжилтнүүд нэн чухал амьдрах орчны үнэлгээг хийсэн⁴⁰. Оюу толгой төслийн нөлөөллийн бүсийг хоёр нэгжид хуваан үнэлгээ хийсэн:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо сум болон ГБДЦГ-ын А, Б хэсгийг хамарсан томоохон (51,415 км²) судалгааны нэгж (өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдэллэн амьдардаг томоохон сүүн тэжээлтний судалгааг хийхэд экологийн үүднээс илүү тохиромжтой);
- Ханбогд, Манлай сумыг хамарсан арай бага (27,375 км²) судалгааны нэгж (уурхай, уурхайн дэд бүтэц, хоёр сумын хэмжээний гидрогеологийн болзошгүй нөлөөллөөс улбаатайгаар төрөл зүйл, төрөл зүйлийн бүлгэмдэл, хувьсан өөрчлөгдөх процесс болон экосистемийн үйлчилгээн д үзүүлэх нөлөөллийг судлахад экологийн үүднээс илүү тохиромжтой).

ОУСК-ийн PS6 стандартын 9-р зүйл, ЕСБХБ-ны PR6 стандартын 13-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтэд үндэслэн судалгааны хоёр нэгжийг нэн чухал амьдрах орчин гэж тодорхойлсон:

- Судалгааны том нэгжийн ихэнх хэсэг нь Азийн зэрлэг илжиг (*Equus hemionus*) буюу хулангийн 1-р зэрэглэлийн нэн чухал амьдрах орчин болдог;
- Судалгааны том нэгж нь бүхэлдээ Аргаль (*Ovis ammon*) болон хар сүүлт зээрний (*Gazella subgutturosa*) 2-р зэрэглэлийн нэн чухал амьдрах орчин болдог;
- Судалгааны жижиг нэгж нь бүхэлдээ Монгол Чэснэй, Могойч бүргэд, боржингийн гарш дээрх цэцгийн бүлгэмдлийн 2-р зэрэглэлийн нэн чухал амьдрах орчин болохын зэрэгцээ усны эргэлтийг зохицуулах, мал идээшлэх (бэлчээр багтана), аргал түлш, цэвэр ус гэсэн экосистемийн дөрвөн үйлчилгээг үзүүлэдэг.

³⁷ Эко-Трэд ХХК (2004): Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх дэд бүтцийн зурвасын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ

³⁸ Оюу толгойн БОННУ (2012). С хэсэг: Нөлөөллийн үнэлгээ. С6-р бүлэг: Биологийн олон янз байдал болон Эко систем. Хавсралт С: Оюу толгой төслийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах стратеги, 4.5-р хэсэг. 2012.

³⁹ Шууд нөлөөлөл нь уурхайн лицензийн талбайн хүрээнд, шууд бус нөлөөлөл нь уурхайн лицензийн талбайн гадна тохиолдоно.

⁴⁰ ТВС болон FFI (2012) Оюу толгой төслийн нэн чухал амьдрах орчны үнэлгээ: ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт 6/ЕСБХБ-ны гүйцэтгэлийн стандартын шаардлага 6. Биодайверсити Консалтанси болон Флора энд Фауна Интернэйшнлийн хэвлэгдээгүй тайлангийн төсөл, 2012 оны 8-р сар.

ОУСК-ийн PS6 стандартад зааснаар дор дурдсанаас бусад тохиолдолд байгалийн амьдрах орчныг ноцтойгоор өөрчлөх, эвдэн сүйтгэх ёсгүй⁴¹:

- Техникийн болон санхүүгийн хувьд өөр боломжит хувилбар байхгүй;
- Төслийн нийт өгөөж нь байгаль орчин, биологийн олон янз байдалд учирсан хохирлоос илүү байх;
- Аливаа өөрчлөлт, эвдрэлийг зохих журмын дагуу бууруулсан.

ОУСК-ийн PS6 сатандартад зааснаар дор дурдсан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд байгалийн амьдрах орчны талбайд төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй:

- 9-р зүйлд заасан төрөл зүйлүүдийн тогтсон тоо толгой болон 9-р зүйлд заасан нэн чухал амьдрах орчны үйл ажиллагаанд нөлөөлөх хэмжигдэхүйц сөрөг нөлөөлөл байхгүй;
- Нэн ховордсон болон ховордсон төрөл зүйлийн тоо толгой буурахгүй;
- Аливаа бага зэргийн нөлөөллийг ОУСК-ын PS6 стандартын 8-р кэйд заасны дагуу бууруулах бөгөөд бууруулах арга хэмжээг биологийн олон янз байдалд хохирол учрахааргүй байхаар боловсруулсан байна.

3.4.1 Суурь нөхцөл

Шинэ замын эргэн тойронд орших биологийн олон янз байдлын суурь нөхцөлийг ОТ БОННУ, 2012 оны Түр замын БОНБНУ-ний суурь судалгаа болон 2014 онд биологийн олон янз байдлын хөндлөнгийн мэргэжилтнүүдийн хийсэн Биологийн олон янз байдлын шинэчилсэн үнэлгээнээс авсан.

Ургамал

Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх шинэ замын маршрутын дагуу 2006 оны 5-р сард (Эко Трэд 2006) ургамлын аймгийн хээрийн судалгаа хийсэн бөгөөд талбайн ургамлын аймгийг “ерөнхийдөө муу” (харьцангуй цөөн төрөл зүйлтэй), уугуул урагмлын тоо “цөөн” гэж тодорхойлсон. Судалгааны үр дүнг ОТ БОННУ⁴²-нд дэлгэрэнгүй тусгасан боловч судалгааны талбай нь Шинэ замын зурвасыг бүрэн хамраагүй. Шинэ замын зурвасыг хамарсан ургамлын аймаг, ургамлын судалгааг 2012⁴³, 2014⁴⁴ онуудад хийсэн бөгөөд Биологийн олон янз байдлын үнэлгээний хүрээнд тус зурвас газарт 2014 оны 5-р сард биеэр очиж танилцсан⁴⁵.

Шинэ замын судалгааны талбайд уугуул, үлдвэр, ховор, ховордсон болон эмийн ургамлууд ургадаг бөгөөд доорх үндсэн бүлгүүдэд хуваагддаг:

- Зонхилогч ургамлан бүлгэмдэл: Хулан хойрго-Баглуур-Сонгино(*Potania mongolica-Anabasis-Allium*); Баглуур-Хулан хойрго-Үетэн(*Anabasis-Potania mongolica*-Poaceae), Баглуур-Үетэн(*Anabasis*-Poaceae), Бударгана-Үетэн-Сонгино(*Salsola*-Poaceae-*Allium*), Улаан бударгана-Сонгино(*Reaumuria soongarica-Allium*), Үетэн- Алаг өвс(Poaceae -forb);
- Зонхилогч зүйл: Говийн хялгана(*Stipa gobica* Roshev), Сайрын хялгана(*Stipa glareosa* P.Smirn), Зүүнгар хазаар өвс(*Cleistogenes songorica* Ohwi);
- Элбэг тархалттай зүйл: Таана(*Allium polyrrhizum* Turcz. ex Rgl.), Сөөгөн боролз(*Ajania fruticulosa* Poljak), Дэлхээ тогторгоно(*Kochia prostrata* (L.) (Schrad), Бууралдуу янгиц(*Ptilotrichum canescens* C.A.Mey), Амманы сэдэргэнэ(*Convolvulus Ammanii* Desf), Өргөст ортууз(*Oxytropis aciphylla* Ldb), Орог тэсэг(*Eurotia ceratoides* (L.) (C.A.Mey),

⁴¹ Ноцтой өөрчлөлт, эвдрэл: (i) газар болон ус ашиглалтад гарсан томоохон, урт хугацааны өөрчлөлтөөс үүдэлтэйгээр амьдрах орчны нэгдмэл байдал үгүй болох, алдагдах; (ii) амьдрах орчны уугуул төрөл зүйлээ тогтвортой хадгалах чадварыг бууруулах өөрчлөлт.

⁴² Оюу толгойн БОННУ (2012). В хэсэг: Суурь үнэлгээ. 7а-р бүлэг: Биологийн олон янз байдал.

⁴³ Nature Friendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” (2012).

⁴⁴ JEMR ХХК (2014) Цагаан хаднаас Гашуун сухайт хүрэх засмал замын БОНБНУ-ний суурь судалгаа, 2015.

⁴⁵ Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын

гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

Ач холбогдол бүхий ургамалд доорх багтана:

- Ховордсон болон нэн ховордсон ургамлын арван зүйл,
- Уугуул ургамлын арван дөрвөн зүйл,
- Үлдвэр ургамлын гурван зүйл: Монгол догар(*Caryopteris mongolica* Bunge), Улаан бударгана(*Reaumuria soongarica* Maxim). Хулан хойрго(*Potaninia mongolica* Maxim), Шар модон хотир(*Zygophyllum xanthoxylon* Bunge Maxim),

Доорх төрөл зүйл нь Монгол Улсын Улаан номд багтсан бөгөөд анагаахын болон анагаах ид шидтэй 20 ургамалд багтана: *Amgdalus mongolica* Maxim - монгол бүйлс *Potaninia Mongolica* Maxim - хулан хойрго, *Caryopteris mongolica* Bunge - монгол догар, *Tugarinovia mongolica* Pjin - шар далан, *Olgaea leucophylla* (Turcz.) Pjin - цагаан навчит хасзул, *Brachanthemum gobicum* Krasch – говийн тост.

Хайлаас мод нь тус бүс нутаг дах өндөр ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын нэг хэлбэр гэж тодорхойлсон бөгөөд бүс нутгийн зэрлэг ан амьтдын хувьд чухал амьдрах орчин нь болдог. Тус мод нь нийгмийн үнэ цэнэтэйн дээр түлшний мод болгон төдийлөн хэрэглэдэггүй. Хайлаас мод нь зарим тохиолдолд шүтлэг, тахилгатай газартай холбогдсон байдаг⁴⁶.


ОТ компани бэлчээрийн ургамлын нөмрөгийг нэн чухал амьдрах орчин гэж тодорхойлсон бөгөөд энэ нь зэрлэг ан амьтан, мал сүргийг хоол тэжээлээр хангаж, орон нутгийн сайн сайхан байдалд чухал хөрөнгө болдог.

Хамгийн ойрын заган ой (*Haloxylon ammodendron*) Шинэ замын маршрутаас баруун тийш 10 км зайтай.

Шинэ замын зурвас нь зүүн талдаа ЭР-ийн зам, баруун талдаа хатуу хучилтгүй нүүрс тээврийн замаар хязгаарлагдан орших тээврийн зурвас дагуу байрлана. Замын барилгын ажил, нүүрсний тээвэрлэлт, замгүй газраар явах, Цагаан хаданд нүүрс буулгах, шилжүүлэн ачихтай холбоотой төрөл бүрийн үйл ажиллагааны улмаас тус зурвасын ургамлын нөмрөг ихээр сүйдсэн. ЭР-ийн замтай зэрэгцээ үргэлжлэх олон салаа зам үүссэн (замын энхэл донхол болон тогтоол усыг тойрон явах ачааны машин, бусад тээврийн хэрэгслийн гаргасан) мөн хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоос зэрэг нь ургамлын нөмрөгт голлон нөлөөлж байна.

⁴⁶ ТВС болон FFI (2012) Оюу толгой төслийн нэн чухал амьдрах орчны үнэлгээ: ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт 6/ЕСБХБ-ны гүйцэтгэлийн стандартын шаардлага 6. Биодайверсити Консалтанси болон Флора энд Фауна Интернэйшнлийн хэвлэгдээгүй тайлангийн төсөл, 2012 оны 8-р сар.

Зураг 3: Тур замын маршрутын дагуух ургамлын төрөл зүйл ⁷



ГХЗ хараахан гараагүй байгаа, мөн бусад мэдээлэл бэлэн байхгүй тул замын зурвасын ижил төстэй талыг харгалзан үзсэний үндсэн дээр 2011⁴⁸ онд гаргасан ГХЗ-ийг суурь мэдээлэл болгон ашигласан. Газар хөндөхийн өмнөх шалгалтыг Цагаан хадны хойд хэсгээс эхэлж, Гашуун сухайтын хилийн боомт дээр дуусгасан. Тус шалгалт нь ургамлын төрөл зүйл болон зохих хамгаалах арга хэмжээг тодорхойлоход голлон анхаарсан. Судалгааг 5 км хэсгүүдэд хуваан явуулсан:

- 1-р хэсэг – Энэ хэсэгт *Nitaria sibirica*, *Reamania songarica*, *Salsola passerine* ургадаг. *Astrathamnus centrali usioticus*, *Oxytropis aciphylla*, *Tamarix onssisima* гэсэн ховор болон нэн ховор ургамлын 3 зүйл олдсон. Барилгын ажлын явцад өнгөн хөрсийг 40 см гүнд хүртэл хуулж, хадгалах нь зүйтэй;
- 2-р хэсэг – Энэ хэсэгт *Salsola passerina*, *Reamania soongarica*, *Sympegma regelii* болон *Anabasis brevifolia* ургадаг. *Tugarinovii mongolica*, *Caragana brachypoda*, *Potanina mongolica* гэсэн ховор ургамлын зүйлүүд олдсон бөгөөд эдгээр зүйл нь эргэн тойрон ургах тул тусгайлан хамгаалах арга хэмжээ шаардлагагүй. Барилгын ажлын явцад өнгөн хөрсийг 20 см гүнд хүртэл хуулж, хадгалах нь зүйтэй;
- 3-р хэсэг – Энэ хэсэгт *Nitaria sibirica*, *Reamania soongarica*, *Salsola passerine* ургадаг. Ховор ургамлын зүйл олдоогүй. Барилгын ажлын явцад өнгөн хөрсийг

30 см гүнд хүртэл хуулж, хадгалах нь зүйтэй;

- 4-р хэсэг – Энэ хэсэгт *Salsola passerina*, *Sympegma regelii* *Reamania soongarica*, *Anabasis brevifolia* ургадаг. *Caragana brachypoda*, *Asticthamnus centrali-asiaticus* гэсэн ховор ургамлын хоёр зүйл илэрсэн боловч эргэн тойрон ургах тул тусгайлан хамгаалах арга хэмжээ шаардлагагүй. Барилгын ажлын явцад өнгөн хөрсийг 20 см гүнд хүртэл хуулж, хадгалах нь зүйтэй.

⁴⁷ Энэ зургийг Nature Friendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-ээс авсан. Тус зурагт Түр замын маршрутыг харуулж байгаа боловч энэхүү баримт бичгийн хувьд Түр замын маршрут нь Шинэ замын маршрутыг төлөөлж чадна.

⁴⁸ Газар хөндөх зөвшөөрөл 111102. Оюу толгой Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр зам. 2011 оны 11-р сарын 17.

Тойруулсан маршрутад⁴⁹ үндэслэн 2012 оны 5-р сард дараагийн ГХЗ-ийг гаргасан ба уг зөвшөөрөлд дурдсанаар тус талбайд Түжгэр баглуур(*Anabasis brevifolia*), *Бор бударгана*(*Salsola passerine*), *Шар мод*(*Sympegma regelii*) өргөн тархсан байна. Өргөст ортууз(*Oxytropis aciphylla*), *Төв азийн лавай*(*Asterothamnus centrali-asiaticus Novopokr*) гэсэн ховор ургамлын хоёр зүйлийг илрүүлсэн. Дээрх ургамал нь эргэн тойрон ургах тул тусгайлан хамгаалах арга хэмжээ шаардлагагүй. Замын дагуу олдсон Одой хайлаас(*Ulmus pumila*) төрөл зүйлийг хөндөхгүй. Тус талбайн өнгөн хөрсийг хадгалах боломжтой бөгөөд хуулах гүн нь 30 см байна.

Сүүн тэжээлтэн

Нүүрсний замыг барихаас өмнө 2003 онд Оюу толгой - Гашуун сухайтын замын дагуу амьтны аймгийн судалгаа явуулсан⁵⁰. Судалгааны талбайд өндөр хүчдэлийн шугамын зурвасыг оруулсан бөгөөд тухайн газар нутагт идээшсэн нүүдлийн ан амьтад болон малчдын бод малыг хамруулах магадлалыг нэмэгдүүлэх үүднээс тус замын зурвасаас илүү том талбайг (Галбын говь болон ГБДЦГ) хамруулсан. Амьтны аймгийн шууд ажиглалтад зам мөр, ичээ нүх, амьтны яс болон малчдын аман мэдээллийг нэмж оруулсан.

Тус талбайд хулан (*Equus hemionus*), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) зэрэг дэлхийн хэмжээний ач холбогдолтой, эртний уугуул нутаг бэлчээрээсээ олноор дүрвэж, устаж буй өвсөн тэжээлтэн амьтад амьдардаг. Хадархаг хэсгээр Сибирийн янгир (*Capra sibirica*), аргаль (*Ovis ammon*) амьдардаг.

Оюу толгойн шууд нөлөөллийн талбай дах хамгаалалтад авах сонирхол татаж буй төрөл зүйл нь Байгаль хамгаалах олон улын холбоо болон Монгол Улсын сүүн тэжээлтний улаан номын жагсаалтад нэн ховордсон амьтнаар бүртгэгдсэн хулан юм⁵¹. Дэлхийн хэмжээнд чухалд тооцогдсон хулангийн тоо толгойг Өмнөговийн бүс нутгаас маш сайн баримтжуулсан хэдий ч энэхүү нүүдлийн төрөл зүйлийн амьдрах орчин нь

замын дэд бүтэц бий болсноор орон нутгийн түвшинд өөр өөр хэмжээтэй газар нутгуудад хуваагдан задарсан⁵².

ОТ-н Эерэг нөлөө ахиу үзүүлэхэд чиглэсэн ажлын явцыг хянах зорилготой Биологийн үндсэн олон янз байдлын хяналт шинжилгээний туршилтын хөтөлбөрийг эхлүүлсэн⁵³. Байршил тогтоох хүзүүвч зүүсэн 20 хуланг 2013 оны 8-р сараас 2014 оны 10-р сарыг дуустал хугацаанд ажиглахад ОТ компанийн замыг 11 хулан нийтдээ 98 удаа, ЭР-ийн замыг 7 хулан нийтдээ 34 удаа хөндлөн гарсан байна⁵⁴. Хулангийн шилжилт хөдөлгөөний мэдээллээс харахад ЭР-ийн зам болон Цагаан хадны өмнөд хэсгийн Нүүрсний замыг нэг удаа хөндлөн гарсан нь доорх 4-р зургаас харагдаж байна. Хулан шөнө эсхүл өглөө эрт зам хөндлөн гарсан бөгөөд мэдээлэлд хийсэн анхан шатны шинжилгээнээс үзэхэд усны тархалт ямар байгаа нь зам гарахад нөлөөлсөн нь тогтоогдсон.

⁴⁹ Оюу толгой ГХЗ 120508. ОТ-ГШ замын ажил – 3-р бүсийн Тойруулсан маршрут. 2012 оны 5-р сарын 25.

⁵⁰ Эко-Трэйд ХХК (2004). Оюу толгой төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 1-р боть, Оюу толгой - Гашуун сухайтын зам болон Дэд бүтцийн зурвасын тайлан, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.


⁵¹ И.Л.Кларк, Ж.Мөнхбат, С.Дуламсүрэн, Ж.И.Бэйллий, Батсайхан, Кинг, Самьяа, Стабб нар (эмхэтгэн, зохиогчид), (2006). Монголын сүүн тэжээлтнийг хамгаалах арга хэмжээний хураангуй. Бүс нутгийн улаан номын цуврал, 2-р боть. Лондонгийн Амьтны нийгэмлэг, Лондон.

⁵² Оюу толгойн БОННУ (2012). В хэсэг: Суурь үнэлгээ 7а-р бүлэг – Биологийн олон янз байдал.

⁵³ Оюу толгойн хэрэгжүүлж буй Биологийн үндсэн төрөл зүйлийн хяналт шинжилгээний төсөл 2 дах жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд илүү мэдээлэлтэй болсноор одоогийн үр дүн өөрчлөгдөнө.

⁵⁴ П.Казенски болон Ж.Пэйн (2014) Говийн зүүн өмнөд хэсэгт хулангийн шилжилт хөдөлгөөнд уул уурхайтай холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил нөлөөлж байгаа нь.

Зураг 4: 2014 онд ЭР-ийн зам болон Нүүрсний замыг хөндлөн гарсан хулангийн мөр.



Тус талбайд орших зам нь хар сүүлт зээрийн шилжилт хөдөлгөөнд саад болж болзошгүй. 2013 оны 8-р сард хар сүүлт зээр ЭР-ийн замд дөхөж ирсэн боловч машинаас үргэж удаа дараа буцсан нь ажиглагдсан. Мөн замын дагуух гүн суваг шуудуу болон шорооны овоолго (ЭР-ээс бусад компанийн машиныг засмал замаар явуулахгүйн тулд гаргасан) нь туурайтан амьтдыг зам хөндлөн гарахад саад болж байгаа нь замын дагуу үлдсэн амьтны мөрөөс тодорхой байна⁵⁵. Хар сүүлт зээрийг ажиглаж буй байршил тогтоогчийн хариу 2015 оны 2-р улиралд бэлэн болно. 2012⁵⁶ болон 2014⁵⁷ онд Шинэ замын зурваст амьтны аймгийн хээрийн судалгаа явуулсан бөгөөд Биологийн олон янз байдлын үнэлгээний⁵⁸ хүрээнд 2014 оны 5-р сард тухайн зурвастай очиж танилцсан. 2014 оны БОНБНУ-ний судалгааг 2014 оны 5-р сард найм хоног явуулсан бөгөөд хар сүүлт зээр, хулан 24 удаа, бор туулай (*Lupus tolia*) нэг удаа ажиглагдсан.

Хэвлээр явагчид болон хоёр нутагтан

Монгол Улсын говийн бүс болон Төслийн талбайд тохиолдох цорын ганц хоёр нутагтан бол Монгол бах (*Pseudepidalea raddei*) юм. Монгол Улсын өмнөд хэсгийн хатуу ширүүн уур амьсгал, хуурай болон хагас хуурай нөхцөлд дасан зохицсон гүрвэл, могойн хэд хэдэн төрөл зүйл нутагшсан бөгөөд 2014 оны БОНБНУ-ний судалгааны явцад хэд хэдэн төрөл зүйл ажиглагдсан. Оюу толгойн шууд нөлөөллийн талбайн хэмжээнд өнөөдрийг хүртэл хийгдээд байгаа судалгаагаар гүрвэлийн найман зүйл, могойн таван зүйл бүртгэгдсэн

Сээр нуруугүй амьтан

Бүсийн болон дэд бүсийн хэмжээнд сээр нуруугүй амьтны аймгийн системтэй судалгаа байхгүй бөгөөд бэлэн гаргасан бүтээл ховор. Монгол улсад 68 зүйлийн шоргоолж байдаг бөгөөд судалгаагаар хүйтэн өвлийн улмаас шоргоолжны тархац хязгаарлагддаг болохыг тогтоосон. Говьд халуун цөлийн шоргоолжны хоёр төрөл зүйл өргөн тархсан нь шоргоолжны бусад а зүйлүүд устаж үгүй болж байгааг илэрхийлэхийн зэрэгцээ цөөн нь давамгайлж, бусад нь устаж үгүй болдог хуулийн жишээ байж болох юм⁵⁹.

⁵⁵ Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

⁵⁶ Nature Friendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” (2012).

⁵⁷ JEMR ХХК (2014) Цагаан хаднаас Гашуун сухайт хүрэх засмал замын БОНБНУ-ний суурь судалгаа, 2015.

⁵⁸ Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

2014 оны БОНБНУ-ний хээрийн судалгаагаар Orthoptera, Hemiptera, Dpitera, Coleoptera, Blattoptera, Hymenoptera зэрэг нэлээд хэдэн сээр нуруугүй амьтад бүртгэгдсэн.

Шувуу

Шувууны ххэнх төрөл зүйл нь Төв Азийн гүнд байрлах говь цөл, талд өргөн тархсан тул Өмнөговийн бүс нутагт өргөн тархсан шувууны төрөл зүйл байхгүй. Оюу толгойн шууд нөлөөллийн талбайд шувууны 137 зүйл бүртгэгдсэн бөгөөд төрөл зүйлийн тоо байнга нэмэгдсээр байна. Эдгээрээс нэг зүйлийг Байгаль хамгаалах олон улсын холбооны ангиллаар “дэлхийн хэмжээнд устаж болзошгүй”, зургаан зүйлийг “дэлхийн хэмжээнд эмзэг”, нэг зүйлийг “дэлхийн хэмжээнд ховордож болзошгүй”, хоёр зүйлийг “анхаарал татахааргүй” гэсэн ангилалд хамруулсан. Монгол Улс дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст оршдог, өвөлдөө хатуу ширүүн уур амьсгалтай тул Монголд суурин амьдардаг шувууны цөөн хэдэн төрөл байдаг. Чухал амьдрах орчныг тодорхойлоход ашигласан судалгааны нэгжүүдэд тодорхойлогдсон буюу мэдэгдсэн 200 гаруй шувууны зүйлээс 174 нь нүүдлийн шувуу ба тэдний зарим нь нүүдэллэхийн өмнө чуулдаг. Оюу толгойн шууд нөлөөллийн бүсэд дээрх нүүдлийн шувууд тохиолдохыг эс тооцвол Оюу толгойн шууд нөлөөллийн талбай нь нүүдлийн шувуудын төрөл зүйлийн 1-ээс их хувь нь дамжин өнгөрдөг нүүдлийн зам болдог байх төлөв одоогоор мэдэгдээгүй бөгөөд түр тогтдог нуур, цөөрөмд усны шувууд хааяа хааяа цуглардаг нь ажиглагдсан.

2014 оны БОНБНУ-ний суурь судалгаагаар 16 зүйлийн шувуу бүртгэгдсэн бөгөөд үүнд *Milvus migrans* (сохор элээ), *Falco naumanni* (зээрд шонхор), *Syrrhaptes paradoxus* (ногтруу), *Columba rupestris* (хадны тагтаа), *Calandrella cheleensis* (дэрсний жиргэмэл), *Eremophila alpestris* (эвэрт бялзуухай), *Podoces hendersoni* (Монгол хуланжороо), *Corvus corax* (хон хэрээ), *Galerida cristata* (согоот божирго), *Passer montanus* (хээрийн бор шувуу), *Pica pica* (алаг шаазгай), *Oenanthe deserti* (цөлийн чогчиг), *Phoenicurus aureus* (дагуур галсүүлт), *Carduelis spinus* (эгэл ногоолзой), *Anthropoides virgo* (өвөгт тогоруу), *Athene noctua* (хотны бүгээхэй) багтана.

2014 оны 7-р сард явуулсан жороо тоодогийн хээрийн судалгааны явцад Таван толгойгоос Гашуун сухайт, Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх замын дагуу нийт 11 бодгаль ажиглагдсан нь тухайн талбайд дээрх амьтны зүйл амьдардаг болохыг нотолж байна. Тэдгээрийн зарим нь засмал замаас 100 м зайд харагдсан.

2013 он, 2014 оны 7-р сард явуулсан могойч бүргэдийн судалгаагаар Шинэ замын зурвасын дагуу шувууны үүр илрээгүй. Хамгийн ойр олдсон шувууны үүр нь Цагаан хаднаас хойш ойролцоогоор 16 км-т байна.

3.4.2 Нөлөөлөл

Замгүй газраар тээврийн хэрэгсэл явах, замын барилгын ажлын нөлөөлөл, замгүй газраар явахаас сэргийлж босгосон далан хаалтын барилгын ажлын улмаас Шинэ зам болон ЭР-ийн замтай зэрэгцээ, тэдгээрийн хооронд орших газар нутагт ноцтой эвдрэл үүссэн. Эвдрэл нь өмнөх эвдрэлд орсон зурвасын хүрээнд байрлах тул 2012 оны Тойруулсан маршрутын барилгын ажилтай харьцуулахад Шинэ замын барилгын ажилтай холбоотой биологийн олон янз байдалд үзүүлэх шууд нөлөөлөл буурсан.

Амьдрах орчин бусних, сүйдэх

Шинэ замын барилгын ажил нь замын нөгөө талаас ирэх усны урсгалыг тасалснаар мөн газрын гадаргын усны эх үүсвэрт эргэн холбогдохгүй ус зайлуулах хоолой болон хиймэл сувгаар усыг дамжуулснаар замын хажуугийн ургамлын нөмрөгт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Замын эргэн тойронд орших ургамлын нөмрөгт Шинэ замын үзүүлэх урт хугацааны шууд бус нөлөөллийг эерэг байх магадлалтай гэж үзсэн. Учир нь засмал зам барьснаар тоосжилтыг бууруулж, замын хоёр урсгалтай зэрэгцэн орших олон салаа замыг нөхөн сэргээх, ургамалжуулах боломжтой болно.

Хулан, хар сүүлт зээр, жороо тоодог зэрэг амьтдыг тухайн бүс нутагт хамгийн өндөр ач холбогдолтой, амьдрах орчны тэнцвэрт байдал алдагдсаны улмаас нөлөөлөлд хамгийн их өртөх магадлалтай, биологийн үнэ цэнэтэй төрөл зүйл гэж тодорхойлсон боловч Шинэ замын барилгын ажил эдгээр төрөл зүйлд ноцтой нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзсэн. Монгол Улсын Өмнийн говийн бүс нутагт амьдардаг могойч бүргэд хайлаас модонд үүрээ засдаг. Цагаан хаднаас зүүн тийш, төлөвлөж буй замын маршрутын дагуу

хэсэг хайлаас мод байдаг ч барилгын ажлын явцад тэдгээрийг хөндөхгүй бөгөөд тэдгээр хайлаас модод нь суурин газарт ойр оршдог, мөн бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөлөлд хэдийнэ өртсөн зэргээс харахад Шинэ замын барилгын ажлын улмаас могойч бүргэдийн амьдрах орчинд нэмэлт нөлөөлөл үзүүлэхгүй.

⁵⁹ Оюу толгойн БОННУ (2012). В хэсэг: Суурь судалгааны үнэлгээ 7а-р бүлэг – Биологийн олон янз байдал.

Өмнө нь эвдрэлд орсон зам тул шинэ замын барилгын ажлаас амьтдын амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл маш бага байна.

Амьдрах орчин эзгүйрэх, хуваагдах

Оюу толгойн уурхай, эрчим хүчний шугам, тээвэрлэлтийн замаас биологийн олон янз байдалд үзүүлж болзошгүй нөлөөлөл болон түүнийг бууруулах арга хэмжээг ОТ компанийн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд⁶⁰ тусган оруулж, хэлэлцсэн. Энэ хэсэгт Шинэ замын барилгын болон ашиглалтын үе шатанд өндөр үнэ цэнэ бүхий биологийн олон янз байдалд⁶¹ үзүүлэх боломжит нөлөөллийг тоймлон оруулсан.

Шинэ замын төслийн талбай нь баруун талдаа Нүүрсний зам, зүүн талдаа ЭР-ийн зам, хойд талдаа Цагаан хадны суурин, урд талдаа Гашуун сухайтын хилийн боомт зэрэг дэд бүтэц, суурин газруудаар бүрэн хүрээлэгдсэн. Хүний үйл ажиллагаа болон дэд бүтцийн одоогийн нөлөөллийг тооцож үзвэл замын хөдөлгөөний одоогийн ачаалаас болоод хулан болон нүүдлийн бусад амьтад тус талбайгаас зугтаах болсон тул⁶² Шинэ замын барилгын ажлаас шалтгаалсан нэмэлт нөлөөлөл үүсэхгүй.

Шинэ замын зурвас дах замууд нь амьдрах орчныг хэдийнэ хуваасан. Төслийн талбай дах замууд нь хар сүүлт зээрийн шилжилт хөдөлгөөнд саад болж байж болзошгүй⁶³ гэж үзэж байгаа хэдий ч Хулангийн сүрэг Төслийн талбай дах замыг хөндлөн гардаг нь тогтоогдсон. Шинэ замын барилгын ажил энэхүү хуваагдлыг улам нэмэгдүүлнэ.

Машинд дайруулах болон ан агнуур хийх, ургамал түүхээс шалтгаалсан шууд болон шууд бус хоргодол

Гашуун сухайт болон Цагаан хаданд суурин газар бий болсон, Шинэ замын зурвасаар дайрч өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хэмжээ зэргийг тооцож үзвэл барилгын түр ажилчид хууль бус ан агнуур хийх, ургамал түүх байдлыг төдийлөн нэмэгдүүлэхгүй гэж үзсэн. Байгалийн ургамал, ан амьтны хууль бус бүтээгдэхүүний эсрэг баримтлах бодлого (ОТ-10-Е9-PLC-1001)-ын хүрээнд ОТ болон гэрээт гүйцэтгэгч нар дээрх үйл ажиллагааг хатуу хориглодог.

Машинд дайруулах болон автын осол гарахаас сэргийлэх үүднээс зам дээр дагаж мөрдөх хурдны хязгаар тогтоох хэдий ч замыг эсрэг урсгалтай байсныг нэг чигийн урсгалтай болгон өөрчилснөөр жолооч нар хурд ихтэй явах хандлага гаргаж

болзошгүй.

3.4.3 Бууруулах арга хэмжээ

Амьдрах орчин сүйдэх

Шинэ замын ГХЗ хараахан гараагүй байгаа боловч өмнөх ГХЗ (Түр замын) хайлаас модыг тайрч болохгүй гэснээс өөрөөр тусгайлсан хамгаалах арга хэмжээ авах шаардлага тавиагүй. Шинэ замыг барихад хайлаас модыг, ялангуяа Цагаан хаднаас урагшаа 1.2 км орчим газарт байх байгалийн урсацыг даган ургаж байгаа хайлаас модыг хөндөхгүй⁶⁵. Хайлаас нь амьдрах орчны нэн чухал бүрэлдэхүү учир ОТ компанийн БОНУС-д тусгасан нөлөөлөл бууруулах арга хэмжээгээр хамгаалагдаж байгаа бөгөөд ОТ компанийн Нэн чухал биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний хөтөлбөрөөр хяналт тавьдаг.

⁶⁰ Оюу толгойн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө, 2014 оны 7-р сарын 19-ний өдрийн хувилбар OT-10-ELN-PLN-1001

⁶¹ ОТ-с тодорхойлсон өндөр үнэ цэнэ бүхий биологийн олон янз байдалд Азийн зэрлэг илжиг буюу хулан (*Equus hemionus*), Аргаль (*Ovis ammon*), Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*); Жороо тоодог (*Chlamydotis undulate*); Могойч бүргэд (*Circaetus gallicus*); 18 зүйлийн нэн ховор ургамал (тухайлбал: *Mongolian Chesney* (*Chesneya/Chesniella mongolica*); боржингийн гарш дээрх цэцгийн бүлгэмдэл; голын эргийн хайлаас; өндөр ургасан заган ой; бэлчээрийн амьдрах орчин зэрэг багтана.

⁶² Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

⁶³ 2014 оны 9-р сард эхэлсэн хиймэл дагуулын программаас авсан мэдээллийг ашиглан Хар сүүлт зээрийн амьдрах орчны хамрах хүрээ болон нүүдлийн хэв шинжийг судална.

⁶⁴ Петра Казенски болон Жон Пэйн (2014 оны 11-р сар) Говийн зүүн өмнөд хэсэгт хулангийн шилжилт хөдөлгөөнд уул уурхайтай холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил нөлөөлж байгаа нь.

⁶⁵ Зэрлэг ан амьтан хамгаалах нийгэмлэг болон Sustainability East Asia байгууллагын гаргасан “Гашуун сухайтын замын зураг төсөлд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн биологийн олон янз байдлын үнэлгээ” (2014).

ОТ компанийн Нөхөн сэргээлтийн журам (OT-10-E9-PRC- 0002-E)-ын дагуу элс, хайрганы карьерыг нөхөн сэргээнэ.

ОТ компани зам барилгын ажлын явцад усны горим өөрчлөгдсөний улмаас амьдрах орчин сүйдэхээс сэргийлж доорх арга хэмжээг авна:

- Ус зайлуулах хоолойн дам нөлөөллөөс сэргийлэхийн тулд ус гаргууруудыг зохих зайд байрлуулах;
- Газрын гадаргуу болон сул үндэстэй ургамалд үзүүлэх нөлөөллийг бууруулах

- үүднээс ус зайлуулах хоолойн сувгийн загварыг зөв гаргах;
- Шаардлагатай бол томоохон ус гаргуураас гарах урсгалыг тараахын тулд задгайруулах шуудуу, далан барих. Усны урсгалын хурдыг бууруулах, урсацыг тараах үүднээс ус гаргуурын дараа чулуун дэвсгэр тавих.

Амьдрах орчныг буснаах

Түр замын ГХЗ-д жороо тоодогийн чуулах улиралд барилгын ажил гүйцэтгэхдээ тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаарддаг бөгөөд үүнд:

- Амьдрах орчин болон экосистемийн үйл ажиллагааг тодорхойлох ажлын өмнө эсхүл тухайн ажлын явцад төлөвлөсөн хөндөх талбайд хээрийн хяналт шинжилгээ хийхгүй байх;
- Ажлын хуваарь гаргах замаар эмзэг мэдрэмтгий талбайд нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх;
- Гүйцэтгэгч болон ажилтнуудад заасан газар нутагт тодорхой үйл ажиллагаа явуулах, машин техник ашиглахыг хязгаарлах зэргээр ан амьтдыг үржлийнх нь үед айлгаж цочоохоос зайлсхийх талаар тодорхой сургалт явуулах.

Тээврийн хэрэгсэлд дайруулснаас үүдэлтэй зэрлэг ан амьтдын хорогдол

ОТ Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-1001) болон Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PLN-0001)-ний хүрээнд нөлөөлөл бууруулах иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Оюу толгой - Гашуун сухайтын замыг ашигладаг бүх хэрэглэгчдэд зохих хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх (ОТ компанийн тээврийн хэрэгслийн хурдны хязгаарын дагуу). (ТМР29);
- Осол гарах эсхүл алжаал ядаргаа тайлахаас бусад тохиолдолд замын хажууд машин тавихыг багасгах;
- ОТ компанийн бүх ажилтнууд болон гүйцэтгэгчдэд нэн чухал биологийн олон янз байдлын онцлогийн талаар тусгай мэдээлэл бүхий, жолоочийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт явуулах;
- Замын аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээнд зэрлэг амьтдад зориулсан тэмдэг тэмдэглэгээг багтаах.

Шинэ замын чиглэлийн дагуу малд зориулсан, мөн зэрлэг ан амьтад ашиглах боломжтой байх хоёр гарц гаргах.

3.4.4 Үлдэгдэл нөлөөлөл

Төслийн талбай хэдийнэ ихээхэн хэмжээгээр хөндөгдөж, эвдрэлд орсон байгаа тул ан амьтад Шинэ замын зурвасаас дайжих явдал төдийлөн нэмэгдэнэ гэж тооцоолоогүй. Шинэ зам нь одоогийн байгаа дэд бүтцийн улмаас үүссэн амьдрах орчны сүйдэлд нөлөөлөх боловч замыг барьснаар замгүй газраар явах нь багасах тул эерэг нөлөөлөл үзүүлнэ (тоосжилт багасах, амьдрах орчин сүйдэх нь буурах гэх мэт).

Зарим нэг нэн чухал биологийн олон янз байдал машинд дайруулсны улмаас үхэж хорогдохыг бууруулах боломжит арга хэрэгслийг ашигласны дараа үлдэгдэл сөрөг нөлөөлөл үүсэх бөгөөд тэдгээрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр нөлөөлөл маш бага байна.

3.4.5 Эерэг нөлөө ахиу үзүүлэх болон Дүйцүүлэн хамгаалах стратеги

ОТ компани биологийн олон янз байдалд Эерэг нөлөө ахиу үзүүлэх үүрэг амлалт хүлээсэн бөгөөд үүний тулд нэн чухал биологийн олон янз байдалд үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Ерөнхийдөө Оюу толгой төсөл амьдрах орчин шууд алдагдах, амьдрах орчин шууд бусаар алдагдах, ан агнуур нэмэгдсэний улмаас хорогдол нэмэгдэх, ургамал түүх нь нэмэгдэх, тээврийн хэрэгсэлд дайруулах, мөргүүлэх, байгалийн махчин амьтдын тоо толгой нэмэгдэх зэргээр биологийн олон янз байдалд зайлшгүй нөлөөлөл үзүүлнэ. Дэлхийн хэмжээнд ховордож буй хулангийн хувьд Өмнөговийн бүс нутаг олон улсын хэмжээнд нэн ач холбогдолтой тул хуланг хамгаалах, энэхүү амьтанд үзүүлэх болзошгүй нөлөөллийг бууруулах нь Оюу толгой төслийн биологийн олон янз байдлын тэргүүлэх зорилт болж байна.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах нь Рио тинтогийн байгаль орчны арга хэрэгсэлд сүүлийн шатны боловч үндсэн алхам болдог бөгөөд компани бизнесийн нэгжүүдэд техник, нийгэм, улс төрийн хувьд боломжтой, тогтвортой төлөвлөгөө боловсруулахад нь туслах зорилгоор Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах удирдамжийн төслийг (Рио тинто, 2010) гаргасан. Энэхүү төлөвлөгөө нь төсөлд зориулан боловсруулсан ОТ компанийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах стратегид дэмжлэг үзүүлдэг. ОТ компанийн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах стратегийн зорилго нь *“төслийн үзүүлсэн үлдэгдэл хохирлыг нөхөхийн тулд нэн чухал биологийн олон янз байдлын үлдэгдлийг нэмэгдүүлэх замаар биологийн олон янз байдалд Эерэг нөлөө ахиу үзүүлэх”* бөгөөд доорх зорилтуудтай. Үүнд:

- Хууль бусаар ан агнах, ургамал түүхийг бууруулах (төрийн байгууллагуудын хулгайн ангийн эсрэг нэгжүүдийн чадавхийг бэхжүүлэх замаар зэрлэг ан амьтантай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, ял шийтгэл оноох үзүүлэлтийг нэмэгдүүлэх; жороо тоодог агнахыг бууруулах);
- Бэлчээрийн менежментийг сайжруулах (малчдад дэмжлэг үзүүлэх, байгаль хамгаалах тогтолцоог хэрэгжүүлэх, уламжлалт бус амьжиргааны тогтолцоог бий болгох, сумын хэмжээнд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх);
- Төслийн бус эрчим хүчний шугамын нөлөөллийг бууруулах (Өмнөговийн бүс нутгийн хаа нэгтээ);
- Тусгай хамгаалалттай газрыг бэхжүүлэх (ГБДЦГ-ын удирдлагыг сайжруулах, Эргэлийн зоо байгалийн нөөц газар болон Шувуудын цуглардаг чухал

газруудын удирдлагыг хянах, хамгаалалттай газрын хил хязгаар, бүсчлэлийг хянах, сайжруулах чиглэлээр засгийн газартай хамтран ажиллах);

- Бүсийн хөгжлийн стандартын шаардлагыг нэмэгдүүлэх (бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, бүс нутгийн төлөвлөлтөд оролцоог хангах замаар);
- Эрх зүйн дэмжлэгийн хүчирхэг механизм бий болгох (урт хугацааны санхүүжилтийн механизм бий болгох, Олон талт хамтын ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх);
- Хяналт шинжилгээ, үнэлгээ хийснээр удирдлагын арга хэмжээг тухай бүр тохируулах боломжтой болн (хор хохирол, үр өгөөжийн хэмжээг тодорхойлох Хяналт шинжилгээ, үнэлгээний систем бий болгох, хэрэгжүүлэх);
- ОТ-н дотоод чадавхийг бэхжүүлэх (Дүйцүүлэн хамгаалах стратегийг дэмжих, удирдах, хэрэгжүүлэх чадавхийг бий болгох).

ОТ компанийн биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах стратегид дурдсанаар дээрх зорилтууд болон туслах үйл ажиллагаа нь мэргэжилтнүүдийн шалгалт туршилтаар орж, хамгийн шилдэг хувилбар мөн болохыг баталгаажуулсан. ОТ компани Өмнөговийн бүс нутагт биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлэх стратегийн төлөвлөгөө боловсруулсан. Тус төлөвлөгөөнд нэн чухал биологийн олон янз байдалд Оюу толгой төслөөс үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг бүрэн шийдвэрлэх тодорхой арга хэмжээнүүд, холбогдох зардлыг тусгасан. Талуудын оролцоог хангах үүднээс ОТ компанийн дүйцүүлэн хамгаалах арга хэлбэрийг боловсруулахдаа мэргэжлийн хүмүүст хандаж, тэднийг татан оролцуулсан бөгөөд тодорхойлон гаргаж ирсэн дүйцүүлэн хамгааллын арга хэлбэрийн талаар оролцогч талуудын санал бодлыг нарийвчлан судлах үүднээс талуудын оролцоог хангах, тэдний санал бодлыг сонсох цогц процессыг явуулсан.

ОТ компанийн Биологийн олон янз байдлын арга хэмжээний төлөвлөгөө (БОЯБАХТ)-нд биологийн олон янз байдлын удирдлага, бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үндсэн арга хэмжээг тоймлон оруулсан. Хамрах цар хүрээ болон шаардлагатай оролцогч талуудын оролцооны улмаас биологийн олон янз байдлын дүүцүүлэн хамгааллыг БОЯБАХТ-нөөс тусдаа, нэмэлт процессоор дамжуулан боловсруулна. Гэвч дүйцүүлэн хамгааллыг төлөвлөх процессын дагуу тодорхойлсон хамгааллын арга хэмжээг БОЯБАХТ-нд бүрэн нэгтгэж оруулсан. БОЯБАХТ-нд биологийн олон янз байдлын удирдлага, бууруулах болон дүйцүүлэн хамгаалах үндсэн арга хэмжээг тусгасан бөгөөд гүйцэтгэлийн тодорхой шалгуур үзүүлэлт, хугацааг заасан байна. БОЯБАХТ-нд заасны дагуу ашиглалтын үе шатанд хийгдэх барилгын ажилтай холбоотой үүрэг амлалт, арга хэмжээг БОЯБУТ-нд тусгасан. Биологийн олон янз байдалтай холбоотой үүрэг амлалтыг Менежментийн холбогдох бусад төлөвлөгөөнд зохих журмын дагуу тусган оруулсан.

Эерэг нөлөө ахиу үзүүлэх урьдчилсан үнэлгээг шинэчилж байгаа бөгөөд 2015 оны дундуур бэлэн болно.

3.4.6 Хяналт шинжилгээ

Шинэ замын барилгын ажил, ашиглалтын явцад биологийн олон янз байдлын хяналт шинжилгээг ОТ компанийн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-ПЛН-1001)-нд зааснаар гүйцэтгэнэ. Одоогийн хэрэгжүүлж байгаа биологийн олон янз байдлын хяналт шинжилгээний газар нутгийн хүрээг тэлж Шинэ замыг багтаана. Хяналт шинжилгээний арга хэмжээнд доорх багтана:

- Зэрлэг ан амьтдын хорогдлыг нэг бүрчлэн бүртгэх;
- Зохих журмын дагуу, зохих мэргэжлийн хүнээр зэрлэг ан амьтдын тооллогыг тогтмол хийлгэх;
- Зохих журмын дагуу хэсэг талбайд ургамлын хяналт шинжилгээ явуулах;
- Газар нутгийн экологийн үйлчилгээний шинжилгээ, ургамлын динамик, амьдрах орчны нарийн түвэгтэй байдал, биологийн олон янз байдлын ажиглалт, судалгаа, шувуу үүрлэх байдлын судалгаа, гадны ургамлын тархалтын хяналт шинжилгээгээр газар нутгийг эргэн сэргээх нөхцөл, нөхөн сэргээлтийн арга хэлбэр, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг хянах;
- Ховор ургамлын тархалт, нягтрал;
- Хайлаас модны тоо хэмжээ, амьдрах чадвар.

3.5 СОЁЛЫН ӨВ

3.5.1 Суурь нөхцөл

2014 оны БОНБНҮ-ний суурь судалгаанд⁶⁶ Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс Шинэ замын чиглэлийн дагуу болон Төслийн талбайд археологийн эд өлгийн зүйлс байхгүй болохыг баталгаажуулж, үүнийг тодорхойлсон гэрчилгээг 2014 оны 6-р сард гаргаж өгсөн болохыг дурджээ.

Шинэ замын зурвас нь өмнө нь үнэлгээ хийсэн Түр замын зурвастай төстэй тул энэхүү үнэлгээний хүрээнд Түр замын нэмэлт үнэлгээг⁶⁷ мэдээллийн нэмэлт эх үүсвэр болгон ашиглана.

Археологийн талбай

ОТ компанийн мэргэжилтнүүд 2012 онд Түр замын чиглэлд соёлын өвийн талбай болон малчдын өвөлжөө, хаваржаа байгаа эсэхийг тодруулах зорилгоор судалгаа хийсэн. Түр замын дагуу долоон хөшөө илрүүлж, бүртгэсэн бөгөөд үүнээс хоёрыг нь чулуун дээрх дурсгал, гурвыг нь хөшөө дурсгал, хоёрыг нь малтсан хөшөө дурсгал гэж ангилсан.

Палеонтологийн талбай

Соёлын өвийн хээрийн судалгааны 1-р үе шатанд явуулсан палеонтологийн талбайн судалгааны дараа 2011 оны 6-р сарын 10-наас 7-р сарын 10-ны хооронд дараагийн хээрийн судалгааг явуулсан. Замын хоёр талаар 3-5 км-ийн зайд Оюу толгойгоос

Гашуун сухайт хүрэх замын дагуу, мөн Оюу толгой - Гашуун сухайтын зам барилгын ажилд зориулан гаргасан ажиллагаатай хоёр карьерын эргэн тойронд судалгааг явуулсан. Палеонтологийн олдвор илрээгүй⁶⁸.

Угсаатны зүйн талбай

Шүтлэгтэй уул, овоо, одоо цагийн болон эртний оршуулгын газар, төрсөн газрыг тэмдэглэсэн чулуу, эерэг ба сөрөг энергитэй газар, морь уралдах зам, ан агнахад суурь, нуувч болдог газар зэрэг оюун санааны ач холбогдол бүхий газрыг тогтоож, бүртгэх зорилгоор Оюу толгой - Гашуун сухайтын зам дагуу болон 220 кВ эрчим хүчний шугамын талбайд 2010 оны эцсээр Угсаатны зүйн үнэлгээ хийсэн. Уг үнэлгээг Монгол Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс (Угсаатны зүй, антропологийн хэлтэс) хийж, Оюу толгой - Гашуун сухайтын зам болон 220кВ эрчим хүчний шугамын дагуу 15 км зурваст явуулсан⁶⁹.

⁶⁶ ЖЭМП ХХК (2014) Цагаан хатнаас Гашуун сухайт хүрэх засмал замын БОНБНУ-ний суурь судалгааны төсөл 2015.

⁶⁷ ОТ (2012) Оюу толгойн БОННУ: Түр зам болон Тойруулсан маршрутын Нэмэлт үнэлгээ.

⁶⁸ Х.Цогбаатар, Ц.Чинзориг (2011) Оюу толгой төслийн дэд бүтцийн байгууламжийг барихаар төлөвлөж буй талбайд хийсэн палеонтологийн урьдчилсан судалгаа, үнэлгээний тайлан. Монгол Улсын ШУА, Палеонтологийн төв, Улаанбаатар.

⁶⁹ Ч.Сампилдондов, Лх.Пүрэвжав (2011). Угсаатны зүйн шинжилгээ буюу Оюу толгой төслийн барилга байгууламжийн (Оюу толгойгоос Гашуун сухайт хүрэх зам, эрчим хүчний шугам, усны шугам хоолой, шинэ нисэх буудал) эргэн тойронд орших шүтлэгтэй болон өв уламжилсан газрууд.

Тухайн газар нутагт оршин суудаг эсвэл улирлын чанартайгаар ашигладаг ард иргэд, малчдад бэлэгдлийн ач холбогдолтой газруудын ангилал. Эдгээр ангилалд доорх багтана:

- Шашны зан үйл үйлддэг онгон дагшин газар: 1-5 жилийн давтамжтайгаар нийтийн баяр ёслол, зан үйл зэрэг шашны тогтсон зан үйл гүйцэтгэдэг ариун дагшин, шүтлэгтэй газар;
- Тахилгатай газар: Шашны тогтсон зан үйл гүйцэтгэдэггүй ч хүмүүс өөрсдөө тахин шүтэж, өглөө шинэ цайныхаа дээжийг өргөдөг ариун дагшин, шүтлэгтэй газар;
- Догшин газар – Хад чулуу, модыг нь хөндөх, хүн очих зэрэгт сөрөг нөлөөлөл үзүүлж, гэнэтийн болон ердийн бусын үзэгдэл, өвчин зовлон тохиолддог хүргэдэг газар. Мөн өмнө нь тахиж шүтдэг, мөргөн залбирдаг байсан уламжлал алдагдаж, шашны зан үйлийг зөв үйлдэх талаар мэдэх хүнгүй болоход тухайн “газар” догширч, сөрөг нөлөөлөл үзүүлдэг;
- Цээртэй газар – энэ ангилалд эртний болон орчин цагийн оршуулгын газар, нас

барагсдын ар гэрийнхэн өөрсдөө сонгосон эсхүл сумын захиргаанаас тогтоож өгсөн оршуулгын газар үүнд багтана. Мөн ямар нэг муу зүйл тохиолдсон, айл буухаас зайлсхийдэг газар үүнд хамаарна;

- Өв уламжилсан газар – өв уламжилсан газар нь нүүдэлчдийн амьдралд нэн чухал бөгөөд өвөг дээдсээс нь өв уламжлан ирсэн эсхүл өөрсдөө шинээр олж авсан бэлчээр, өвөлжөө, худаг, усны эх үүсвэрийг хэлнэ. Мөн төрсөн газар, Монголын уламжлалт тоглоом чулуун гэрийн буурь, ан агнуурын суурь, нуувч болдог газар, морь уралдах зам үүнд хамаарна.

Түр замын ойр орчмын газар нутагт нүүдэллэн амьдардаг малчид Цагаан хадг догшин, шүтлэгтэй газар гэж үздэг. Гэхдээ ховор нандин, шүтдэгтэй модыг өмнө нь тайрсан бөгөөд Цагаан хадны суурин нь Ханбогд сумын хамгийн их оршин суугчидтай газар болсон. Тус газар нутгийг тойрон амьдарч ирсэн малчид тухайн газар нь онгон дагшин бөгөөд тэдний өсөж төрсөн, өвөг дээдэс нь амьдарч, шүтэж ирсэн газар гэж ярьсан. Тиймээс ариун дагшин газрын тухай ойлголт зарим тохиолдолд бодит газартай холбоогүй байх тохиолдол байдаг.

Шинэ замын дагуу орших талбайд өөр ариун дагшин газар байхгүй.

3.5.2 Нөлөөлөл

Соёлын биет өвд (биет баялаг) үзүүлэх биет эвдрэл гэмтэл нь үндсэндээ Шинэ замын барилгын ажилтай холбоотойгоор үүсэж болзошгүй. Үүнд:

- Өнгөн хөрс хуулах, ил карьер гаргах, үйлдвэр, тоног төхөөрөмжийг байрлуулах зэрэг газар хөндөх үйл ажиллагааны улмаас соёлын биет өвд үзүүлэх нөлөөлөл, эвдрэл гэмтэл;
- Барилгын ажилд ашиглах тээврийн хэрэгсэл, машин техникийн хөдөлгөөнөөс үүсэх тоос, доргилтын улмаас соёлын биет өвд үзүүлэх нөлөөлөл, эвдрэл гэмтэл;
- Төслийн ажилчид болон тухайн бүс нутагт ирж очигсод соёлын биет өвд нөлөөлөх эсхүл санаатайгаар эвдэж сүйтгэх.

Шинэ замыг өмнө нь байсан маршрут, өмнө нь малталт хийсэн хоёр талбайтай зэрэгцээ барьж байгаа тул газар хөндөх ажил, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, үйлдвэр, тоног төхөөрөмжийн улмаас археологийн дурсгалт долоон талбайд үзүүлэх болзошгүй нөлөөллийг **маш бага** байна гэж үзсэн.

Шинэ замд ойрхон орших соёлын өвийн талбай байхгүй бөгөөд болзошгүй нөлөөллийг **маш бага** байна гэж тооцоолсон.

Ашиглалтын үе шатанд археологийн талбайд үзүүлж болзошгүй эвдрэл гэмтлийг ийг **маш бага** байна гэж үзсэн.

Тухайн бүс нутагт хөл хөдөлгөөн ихэссэний улмаас археологийн дурсгалт талбайд үзүүлэх болзошгүй нөлөөллийг **бага байна** гэж тооцоолсон. Шинэ замыг бүрэн дуусгаснаар Өмнөговийн бүс нутгаар дамжин өнгөрөх аяллын хугацаа үлэмж хэмжээгээр буурах бөгөөд тус бүс нутаг дах соёлын өвийн нутаг дэвсгэр, талбай руу зорчих хүмүүсийн тоо нэмэгдсэнээр болзошгүй эвдрэлийн хэмжээ нэмэгдэнэ.

3.5.3 Бууруулах

Соёлын өвд үзүүлэх нөлөөллийг удирдан зохицуулах чиглэлээр ОТ компаниас авч хэрэгжүүлэх арга хэмжээнд Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөнд (ОТ-10-PLN-0002) заасан Газар хөндөх зөвшөөрлийн (ГХЗ) журам, Археологийн олдвор олдоход баримтлах журам (АООБЖ), Соёлын өвийн талбайг хамгаалах төлөвлөгөө (СӨТХТ) зэрэг багтана.

ГХЗ хараахан гараагүй байгаа. ГХЗ-ийн процесс нь аливаа газар хөндөх ажлын өмнө ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн талбайд археологийн болон палеонтологийн олдвор бүхий соёлын ач холбогдолтой талбай байхгүй болохыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулуулсан байхыг шаарддаг. ОТ компанийн БХНХ-ын хэлтэс нь ОТ компанийн холбогдох хэлтэс эсхүл нэр бүхий гүйцэтгэгч компанид гаргаж өгөхийн өмнө ГХЗ-ийг батлахад ашиглах БХНХ-ийн шалгах хуудасны хамтаар Байгаль орчны хэлтэст ГХЗ-ийг гаргаж өгөх ёстой. ОТ компанийн мэргэжилтнүүд газар хөндөхийн өмнөх шалгалт хийх явцдаа уг шалгах хуудсыг бөглөж, Соёлын өв хариуцсан ахлах мэргэжилтэн гарын үсэг зурна.

Газар хөндөх ажил гүйцэтгэх тохиолдолд уг ажилд зориулан гаргасан Газар хөндөх зөвшөөрөлд олдвор олдсон тохиолдолд баримтлах журмыг заасан байдаг. ОТ компани Археологийн олдвор олдоход баримтлах журмыг Рио тинтогийн соёлын өвийн зөвлөхүүдийн хамт боловсруулсан бөгөөд археологийн болон палеонтологийн үлдвэрүүд зэрэг соёлын болон түүхийн ач холбогдол бүхий өмнө шинээр олдож буй зүйлсийн аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг хангах, зөв арчлах зорилгоор гаргасан. ОТ компанийн бүх ажилтан, гүйцэтгэгч нар уг журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Соёлын өвийн талбай дэд бүтцэд ойрхон байх тохиолдолд ажлыг гүйцэтгэх хугацаанд талбайн удирдлагын шаардлагыг дэлгэрэнгүй тусгасан Төслийн талбайг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Тус төлөвлөгөөнд цаашдын менежментийн асуудал болон осол зөрчлийн тайлагналд тавих шаардлагуудыг дэлгэрэнгүй тусгасан.

3.5.4 Үлдэгдэл нөлөө

Үлдсэн таван археологийн дурсгалт газарт малталт хийсний дараа соёлын өвд үзүүлэх нөлөөллийг **маш бага** гэж үнэлсэн.

3.5.5 Хяналт шинжилгээ

Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө (ОТ-10-PLN-0002) -нд заасан хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд ОТ компанийн байгаль орчны ажилтнууд археологийн дурсгалт газрыг тогтмол хянадаг. ОТ компани гүйцэтгэгч компаниуд ГХЗ-ийн нөхцөл болзолд нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг тогтмол хяналт шалгалт явуулдаг. Харин улсын чанартай замын ажил дуусахад гүйцэтгэгчийг төслийн талбайгаас буцаан татсан бөгөөд хууль эрх зүйн хэрэгжилтийн хяналт шалгалт хийгээгүй байна.

4. ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Олон талт хамтын ажиллагааны төлөвлөгөөнд (ОТ-05-PLN-0001) баримтжуулсанчлан ОТ компани нь нөлөөлөлд өртсөн малчид, олон нийт, засгийн газар болон ТББ-уудтай тасралтгүй хамтран ажиллах үүрэг хүлээсэн. ОТ БОННУ⁷⁰-нд зааснаар Шинэ замын зурвас нь Шууд нөлөөллийн бүсэд байрлана.

4.1 МАЛЧИД

2011 онд Шинэ замын маршрутын талбайд суурьшиж буй таван малчин өрхийг тогтоосон. Дээрх өрхүүд таван жилийн хугацаатай нөхөн олговрын гэрээнд гарын үсэг зурсан. ОТ компанийн Олон нийттэй харилцах хэлтсийн ажилтнууд 2015 оны 1, 3-р сард малчин өрхүүдээр орж, төлөвлөж буй Шинэ замын талаар мэдээлэл өгсөн. Энэхүү талбайн айлчлалын үеэр өөр малчин өрх бүртгэгдээгүй.

4.2 ГБДЦГ-ЫН ЗАХИРГАА БОЛОН ХАЙРХАН БАГИЙН ЗАСАГ ДАРГА

2015 оны 1, 3-р сард ГБДЦГ-ын Б хэсгийн захиргаа болон Хайрхан багийн Засаг даргатай зөвлөгөөн хийсэн. Шинэ зам нь Цагаан хаднаас Гашуун сухайтын хилийн боомт хүрэх тээвэрлэлтийн нэгдсэн шийдэл болох тул хоёр тал Шинэ замыг барих нь Түр зам болон Тойруулсан маршрутыг ашиглахаас илүү гэж үзсэн.

ГБДЦГ-ын захиргаанаас доорх зөвлөмжийг өгсөн:

- ОТ компани ГБДЦГ-ын Б хэсэгт зэрлэг ан амьтдад зориулсан нарны эрчим хүчээр ажилладаг мотортой гүний худаг гаргах.
- ОТ компани Төслийн зураг төсөлд мал/зэрлэг ан амьтан гарах нэг гарц, явган хүний нэг гарц тусгах. Санал болгож буй гарцын координатуудыг ОТ компанийн БИБ-т өгсөн. ОТ компани урьдчилан сэргийлэх арга хэмжээ болгон малд зориулсан хоёр гарц гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр зэрлэг ан амьтан ч ашиглах боломжтой болно.

⁷⁰ Оюу толгойн БОННУ (2012). А хэсэг: танилцуулга, үндэслэл, А1-р бүлэг: Танилцуулга

4.3 ЦАГААН ХАД

2012 оны БОННУ-ний судалгааны^{71,72} хүрээнд зөвлөхүүд Цагаан хад багийн Засаг даргатай ярилцлага хийсэн. Тус ярилцлагаар суурин газар руу шилжин ирэгсдийн асуудал болон шилжин ирэгсдийн урсгалаас үүдэлтэй нөлөөллийг удирдах асуудалд голлон анхаарсан. Дүгнэвэл:

- Суурин газарт амьдардаг хүүхдүүдэд зориулсан дэд бүтэц, барилга байгууламж дутагдалтай, мөн тус газар нутгаар дамжин өнгөрч буй нүүрсний машинд үзүүлэх үйлчилгээ албан ёсны бус шинж чанартай байгаа;
- ГБДЦГ-ын хамгаалалтын бүсэд замгүй газраар явсны улмаас байгаль орчны эвдрэл гэмтэл нэмэгдэж байгаа, түлшний мод, эмийн болон бусад ургамлын зүйлийг түүж байгаа;
- Аялал жуулчлалаар явж буй хүмүүсийн байгаль орчны талаарх ерөнхий мэдлэг ойлголт дутмаг байгаагаас хог хаягдлаа зохих журмын дагуу зайлуулдаггүй нь хог хаягдал ихсэхэд хүргэж байгаа;
- Нүүрсний машинаас гарч буй хорт утааны хяналт дутмаг байгаагаас орчны агаарын чанар муудахад нөлөөлж байгаа;
- Саяхныг хүртэл суурин газарт хог хаягдлын удирдлагын албан ёсны байгууламж байхгүй байсан.

Засаг дарга суурин газрын оршин суугчдад зориулж байгаль орчны эмзэг, мэдрэмтгий байдлын талаар мэдлэг ойлголт олгох сургалт зохион байгуулах, мөн ГБДЦГ-ын эмзэг мэдрэмтгий, хамгаалалттай бүс нутагт нэвтрэхийг хориглосон тэмдэг тэмдэглэгээ байрлуулах удирдлагын төлөвлөгөө гаргахыг санал болгосон.

5. АЖИЛЛАХ ХҮЧ БОЛОН АЖЛЫН НӨХЦӨЛ

ОТ төслийн талбайд ажиллаж буй Гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нар Гүйцэтгэгчийн менежментийн тогтолцоо (ОТ-07-PLN-0001)-нд заасан ОТ компанийн тавьж буй бүх шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй. Гүйцэтгэгч болон Туслан гүйцэтгэгч нар ОТ компанийн бодлого, журмыг дагаж мөрдөх буюу өөрсдийнхөө ижил төстэй журмыг ОТ компаниар батлуулан хэрэгжүүлэх замаар хууль эрх зүйн хэрэгжилтийг хангана.

Харин ОТ компани ГХЗ-ийн журмыг хариуцан хэрэгжүүлэх бөгөөд гүйцэтгэгчийн ажлын хамрах хүрээг гаргахад ашигласан эрсдэлийн үнэлгээгээр олж илрүүлсэн зүйлсийг тусган оруулна. Энэхүү ажлын хамрах хүрээнд Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажилтай холбоотой эрсдэлийн шинжилгээг хийх, төслийн стандартыг хангахгүй, нийцэхгүй байх эрсдэлийг үнэлэх ажил багтана. ЭМААБОУС нь гүйцэтгэгч нарт ч мөн адил хамаарах бөгөөд гүйцэтгэгчийн бүх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг аюулгүй бөгөөд ОТ компанийн стандарт, журамд нийцсэн эсэхийг шалгах үзлэг шалгалт, үнэлгээ хийх процессыг багтаасан байна.

Гүйцэтгэгчийн хяналт шинжилгээнд гол анхаарах зүйл нь хөдөлмөрийн гэрээний

харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөхгүй байлгах, ажлын талбай болон ажилчдын амьдрах кэмпэд ажиллах, амьдрах нөхцөлийг хангуулах асуудал юм. Шинэ зам дээр ажиллах ажилтан Оюу толгой болон Цагаан хадны хооронд замын дунд орчимд Түр замын хажууд байрлах кэмпэд байрлан амьдарна. ОТ компанийн кэмп нь ОТ компанийн кэмпийн стандарт болон Зан байдлын дүрмийн (HR-ST-01) дагуу нарийн чанд удирдлага, хяналттай байна. Гүйцэтгэгч нарын ажлын гүйцэтгэлийг ОТ компанийн бодлого, стандартад харьцуулан үнэлэх хууль эрх зүйн хэрэгжилтийн хяналт, баталгаажуулалтыг тогтмол гүйцэтгэнэ.

6. ХУРИМТЛАГДСАН НӨЛӨӨЛӨЛ

Энэ хэсэгт Шинэ замын хуримтлагдсан нөлөөллийг түүний эргэн тойрны байгаль орчин, нийгмийн давамгайлал нөхцөл байдлын хүрээнд авч үзнэ.

Замгүй газраар явдгаас олон салаа зам хэдийнэ гарсан тээвэрлэлтийн зурвас дотор шинэ замыг барьж байгаа. Шинэ зам барьснаар тухайн бүс нутагт тээвэрлэлтийн тогтсон зурвас бий болж одоо байгаа замтай харьцуулахад илүү үр ашигтай нөлөөлөл үзүүлнэ. Шинэ зам нь Цагаан хад болон Гашуун сухайтын хоорондох газрын ерөнхий эвдрэлийг бууруулж, тухайн бүс нутагт байгаа Түр зам болон замгүй газраар явсан шороон замын хэсгүүдийг нөхөн сэргээх боломж олгоно. Ингэснээр замгүй газраар явахад үүсэх тоосжилтыг бууруулж, ЭР-ийн замтай хамт замын нэгдсэн нэг систем бий болсноор замын аюулгүй байдлыг сайжруулна.

⁷¹ Nature Friendly байгууллагын боловсруулсан “Оюу толгой - Гашуун сухайтын замын 3-р бүсийн Түр замын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” (2012).

⁷² 2012 оны судалгаанаас хойш ОТ компани төлөвлөсөн шинэ маршрутын талаар Хайрхан багийн Засаг даргатай хамтран ажиллаж ирсэн.

Тухайн бүс нутаг дах Нүүрсний зам болон ЭР-ийн замын улмаас нутаг дэвсгэр нэгэнт хуваагдсан байгаа тул нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг хэрэгжүүлсний дараа Шинэ замын хуримтлагдсан нөлөөлөл маш бага байна. ОТ компани мал гарах гарц байгуулах замаар нутаг дэвсгэр хуваагдсан нөлөөллийг бууруулахаар төлөвлөж байгаа. Нүүрсний зам болон ЭР-ийн зам дээр үүнтэй ижил төстэй арга хэмжээ хэрэгжүүлэхгүй бол нөлөөлөл бууруулах энэхүү арга хэмжээ нь нутаг дэвсгэр хуваагдах нөлөөллийг илүү өргөн хүрээнд бууруулах боломжгүй.

7. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ДҮГНЭЛТ

Шинэ зам нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутаг (ГБДЦГ-ын Б хэсэг) гэж тогтоосон талбайд байрлана. Үр дүнтэй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлснээр байгаль орчны болон нийгмийн үлдэгдэл нөлөөллийг маш бага түвшинд байлгахаар тогтсон. Дүгнэвэл:

- Шинэ замыг ЭР-ийн засмал замтай зэргэлдээ орших хөндөгдөж, эвдэрсэн газар нутагт барьснаар биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулна;
- ГХЗ олгосноор гүйцэтгэгч нар тус зөвшөөрлийн нөхцөлд нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг хянана;
- ОТ компанийн ЭМААБОУС, ОННХУС болон тэдгээрийг дагалдсан ҮАУТ, журам, бусад баримт бичгүүдийг дагаж мөрдөнө;
- Шинэ зам тэр чигээрээ ГБДЦГ-ын Б хэсгийн Хязгаарлалтын бүс болон ан амьтдын Нэн чухал амьдрах орчин дотор байрлаж байгаа тул уг замын улмаас биологийн олон янз байдалд үзүүлэх болзошгүй нөлөөллийг бууруулах нь ОТ компанийн хувьд биологийн олон янз байдалд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэх үүрэг амлалтдаа хүрэхэд нь маш чухал.